



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЭЭГҮЙ,
ХЯНАЛТ СУЛ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУДЫН УЯЛДАА
ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

**"ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН"-Д ОЛГОСОН ЗЭЭЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТ,
ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: ӨВА-2026/21-14-ШТА-ГА



Энэхүү аудитын тайлангийн цахим хувилбарыг дээрх QR кодоор, тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг доорх хаягаар авна уу.
www.audit.mn, www.open.audit.mn

Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын Дарга,
Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253
Цахим шуудан: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер П.Хорлоосүрэн
Утас: 70323108
Цахим шуудан: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Баяртогтох
Утас: 70323833
Цахим шуудан: Bayartogtokhb@audit.gov.mn

Аудитор Г.Нинжбадгар
Утас: 70323833
Цахим шуудан: Ninjbargarg@audit.gov.mn

Аудитор Р.Цэрэндолгор
Утас: 70323833
Цахим шуудан: TserendolgorR@audit.gov.mn

Аудитор Д.Очирбат
Утас: 70323833
Цахим шуудан: OchirbatD@audit.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	4
БҮЛЭГ 1. “ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗОРИЛТОТ ҮР ДҮН БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА.	7
1.1. Малчдын сайн дурын үндсэн дээр хорших үйл ажиллагааг дэмжиж, хамтын эдийн засгийг хөгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.	7
1.1.2. "Шинэ хоршоо—Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутагт хэрэгжүүлэхээр тусгасан зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.....	7
1.1.3. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий салбар дундын уялдааг хангах үндэсний хороо нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо сул байна.	10
БҮЛЭГ 2. ОРОН НУТАГТ ХАМТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРЧИМ, ХОРШООЛЛЫН АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ИДЭВХЖҮҮЛЭХ, УЛМААР ОЛОН ГИШҮҮНТЭЙ ХОРШООЛСОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ САНХҮҮ, ТАТВАР, ЗЭЭЛИЙН БОДЛОГООР ДЭМЖИХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	12
2.1. Хоршоо нь хуульд заасан шаардлагыг ханган шинээр үүсгэн байгуулагдсан боловч засаглал, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.	12
2.1.1. Хоршоог үүсгэн байгуулсан гэрээнд хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан боловч “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ болон холбогдох журамд зээлийн үлдэгдэлтэй хоршоог татан буулгахтай холбоотой хязгаарлалт, зохицуулалт тусгагдаагүй байна.	12
2.1.2. Хоршооны дүрэмд хоршоог үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.	13
2.1.3. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 96.6 хувь нь хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг байршуулаагүй байна.	15
2.1.4. Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийг бүрдүүлээгүй байна.	16
2.1.5. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршооны 51.4 хувь нь санхүүгийн тайлан гаргаж, бүртгэл хөтлөөгүй байна.....	16
2.2. Хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хэвийн боловч зээл олгох шалгуур, зориулалтын ашиглалт, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.	18
2.2.1. Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй гэрээний зохицуулалт хангалтгүй, зарим зээлдэгч зээл хүсэгчид тавигдах шаардлагыг хангаагүй байна.	18
2.2.2. Зээлдэгчдийн зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хэвийн төлөгдөж, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байна.	23
2.2.3. Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбар, Зээлийн батлан даалтын сан, арилжааны банк нь гэрээний үүргээ биелүүлээгүй, зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг хангалтгүй байна.	24
2.2.4. Аудитын түүвэрт хамрагдсан хөнгөлөлттэй зээлд хамрагдсан малчдын ихэнх нь зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнд хүрсэн боловч, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.	26
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	37
ЗӨВЛӨМЖ:.....	38

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗГХХГ	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МБ	Монгол банк
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДГ	Нийгмийн даатгалын газар
СЯ	Сангийн яам
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт-1	Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээ	6
Хүснэгт-2	Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээ	6
Хүснэгт-3	"Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний чиглэл, арга хэмжээ	7
Хүснэгт-4	Хоршоодын үйл ажиллагааны чиглэл, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа	9
Хүснэгт-5	"Шинэ хоршоо" хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл	10
Хүснэгт-6	Татан буугдсан хоршооны мэдээлэл	12
Хүснэгт-7	Хоршооны хөгжлийн санд байршуулсан хөрөнгө	15
Хүснэгт-8	Хоршоодын татвар, НДШ-ийн тайлан гаргасан байдал	17
Хүснэгт-9	"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн гэрээний нөхцөлөөс...	18
Хүснэгт-10	"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн гэрээний зээл хүсэгчид тавигдах шаардлага.	18
Хүснэгт-11	"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн мэдээ	19
Хүснэгт-12	"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн зориулалтаар ангилсан үзүүлэлт	19
Хүснэгт-13	Зээлдэгчдийг малын тоогоор бүлэглэсэн тоон үзүүлэлт	20
Хүснэгт-14	Өвөрхангай аймгийн малчин өрх, зээлдэгчийн тоон үзүүлэлтүүд	21
Хүснэгт-15	Хоршоонд эзэмшүүлсэн газрын мэдээлэл	22
Хүснэгт-16	Хаагдсан зээлийн хэмжээ банкаар	24
Хүснэгт-17	Зээлийн батлан даалтын сангаас хяналт хийсэн мэдээлэл	26
Хүснэгт-18	"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн зарцуулалт, зориулалтаар	27

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хоршооны зорилго, эрх үүрэг, хариуцлагын мэдээллээ тусгасан эсэх	12
Дүрслэл 2	Хоршооны хөрөнгийн төрөл	14
Дүрслэл 3	Хоршооны дүрэмд заасан нийт хөрөнгийн хэмжээгээр харуулсан бүтэц	14
Дүрслэл 4	Хоршооны заавал байршуулах хөрөнгө	15
Дүрслэл 5	Хоршоодын санхүүгийн тайлан илгээсэн мэдээлэл	17
Дүрслэл 6	Зээлдэгчдийг зээлийн хэмжээгээр бүлэглэсэн тоон үзүүлэлт	20
Дүрслэл 7	Зээлдэгчийг зээлийн батлан даалтын хувиар бүлэглэсэн тоон үзүүлэлт	22
Дүрслэл 8	Аймгийн хэмжээнд зээл авсан зээлдэгч болон зээлийн дүн	26

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт-1	Санхүүгийн тайлан ирүүлээгүй хоршоодын жагсаалт	31

АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар “Аудитын сэдэв батлах тухай” тогтоолоор баталсан Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэх аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026 оны А/179 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-нд үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Засгийн газрын 2024 оны 166 дугаар "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоолын хүрээнд малчинд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрөөс Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцож байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Засгийн газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолоор "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд аймаг, сумдын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Монголбанк, Хаан банк, Төрийн банк, Хас банк, Зээлийн батлан даалтын сан Хангайн бүсийн салбар зэрэг шалгадагч болон хамрагдагч талууд, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд зээл авсан 414 хоршооны улсын бүртгэл, дүрэм, санхүүгийн тайлан, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, мөн дээрх хоршоодын гишүүн 1486 малчдын зээлийн гэрээ болон зээлийн бусад материал, зээлийн ашиглалт, зарцуулалтын хяналт, баримт материалыг хамруулав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер П.Хорлоосүрэн хэрэгжүүлэн гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор Б.Баяртогтох, аудитор Г.Нинжбадгар, Р.Цэрэндолгор, Д.Очирбат нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэсэн.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-аас соёрхон баталж, 4 дүгээр сарын 24-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Засгийн газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэхээр 5 (тав) их наядын “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг баталж, 2 чиглэлийн хүрээнд 13 арга хэмжээг тусгасан байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд Өвөрхангай аймагт хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээг арилжааны банкуудтай хамтран зохион байгуулж 2024, 2025 онд нийт 1486 зээлдэгчид 51,253.3 сая төгрөгийн зээл олгосон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээ /сая төгрөгөөр/

№	Банкны нэр	Хоршооны тоо	Малчны тоо	Олгосон зээлийн дүн
1	Хаан банк	213	652	21,151.0
2	Төрийн банк	200	828	29,917.2
3	Хас банк	1	6	185.1
Нийт		414	1,486	51,253.3

Эх сурвалж: Монголбанкны зээлийн мэдээллийн сан

“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан малчдыг сумдаар харуулбал:

Хүснэгт 2. Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээ /сая төгрөгөөр/

д/д	Сумын нэр	Зээлдэгчдийн мэдээлэл						Нийт	
		/Хаан банк/		/Төрийн банк/		/Хас банк/			
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Арвайхээр	39	1,233.7	37	1,559.0			76	2,792.7
2	Баруунбаян-Улаан	11	310.0	9	270.0			20	580.0
3	Бат-Өлзий	24	748.4	86	2,713.0			110	3,461.4
4	Баянгол	88	2,950.4	45	1,670.0			133	4,620.4
5	Баян-Өндөр	28	790.5	60	2,182.6			88	2,973.1
6	Богд	3	59.8	40	1,385.0			43	1,444.8
7	Бүрд	17	650.0	12	440.0			29	1,090.0
8	Гучин-ус	25	852.5	13	519.0			38	1,371.5
9	Есөнзүйл			13	580.0			13	580.0
10	Зүүнбаян-Улаан	151	4,532.0	169	5,866.0			320	10,398.0
11	Нарийнтээл	2	67.0	9	413.0			11	480.0
12	Өлзийт	9	347.0	3	150.0			12	497.0
13	Сант	28	1,096.0	52	2,420.0	6	185.1	86	3,701.1
14	Тарагт	39	1,327.5	44	1,652.0			83	2,979.5
15	Төгрөг	43	1,552.6	19	643.0			62	2,195.6
16	Уянга	90	2,627.7	89	3,111.7			179	5,739.4
17	Хайрхандулаан	17	695.0	8	168.0			25	863.0
18	Хархорин	15	605.0	90	3,296.4			105	3,901.4
19	Хужирт	23	706.0	30	878.5			53	1,584.5
Нийт		652	21,151.0	828	29,917.2	6	185.1	1,486	51,253.3

Эх сурвалж: Монголбанкны зээлийн мэдээллийн сан

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:
**“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТ СУЛ,
 ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУДЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ
 БАЙНА.**

**Аудитаар нийт 13,519.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 3 зөвлөмж өгч, 13,519.7 сая
 төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцов.**

**БҮЛЭГ 1. “ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН
 ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ЗОРИЛТОТ ҮР ДҮН БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА.**

**1.1. Малчдын сайн дурын үндсэн дээр хорших үйл ажиллагааг дэмжиж, хамтын эдийн
 засгийг хөгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого,
 зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.**

1.1.2. "Шинэ хоршоо—Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутагт
 хэрэгжүүлэхээр тусгасан зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын
 өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан
 сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой
 хөгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2024 оны 166 дугаар "Шинэ хоршоо хөдөлгөөн"
 өрнүүлэх тухай тогтоолыг баталсан байна.

Тус тогтоолыг хэрэгжүүлэхээр 5 (тав) их наядын "Шинэ хоршоо-Чинээлэг малчин"
 арга хэмжээний төлөвлөгөөг баталж, 2 үндсэн чиглэлийн хүрээнд, 13 арга хэмжээг 20 гаруй
 байгууллага хамтран хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хүснэгт 3. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний чиглэл, арга хэмжээ

№	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэмжээний тоо	Санхүүжилтийн эх үүсвэр	Хариуцах болон хамтран хэрэгжүүлэх байгууллагууд
1	Хоршооны гишүүн малчинд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	4	Банк, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	ХХААХҮЯ, СЯ, ХНХЯ, ХХҮЕГ, МБ, Арилжааны банк, ЗБДС
2	"Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг идэвхжүүлэх, сурталчлах	9	Төсөл, хөтөлбөр, төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	ЗГХЭГ, ЗГХХГ, ХХААХҮЯ, ЦХХХЯ, СЯ, МБ, ЗБДС, ЖДҮГ, ҮСХ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХК, "Хөдөө аж ахуйн бирж" ХК, "Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" УТҮГ, Монголын хоршоодын үндэсний холбоо, Мэргэжлийн холбоод, Удирдлагын академи, аймаг, нийслэлийн ЗДТГ, ХХААГ

Эх сурвалж: legalinfo.mn

Дээрх тогтоолыг 2024-2029 онд хэрэгжүүлэхээр баталсан ч суурь үзүүлэлт, хүрэх түвшнийг он тус бүрээр нарийвчилж бодитой тусгаагүй нь тухайн жилд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй, үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын оролцоо тодорхойгүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл бүрэн бус, үр дүнг нэгтгэн тайлагнаагүй нь хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.

"Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоолд тус хөдөлгөөний ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгасан байна.

Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.3-т “Малчдын хоршоог чадавхжуулна” зорилтын хүрээнд дараах 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг аймгийн хэмжээнд үргэлжлүүлэн өрнүүлж, малчдын хоршоодод хөнгөлөлттэй зээл олгох, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоог сайжруулна.
- Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулж, хоршооны загвар төслүүдийг бэлтгэж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэн, сургалт зохион байгуулна.

Мөн Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/11 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 2.2.3 “Малчдын хоршоог чадавхжуулна” зорилтын хүрээнд “Мах сүүний эрчимжсэн аж ахуй, малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх, малчдын хоршоог дэмжих чиглэлээр ажиллах” арга хэмжээг тусгажээ.

Дээрх бодлогын бичиг баримтуудын “Малчдын хоршоог чадавхжуулах” арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан үзэхэд биелэлтийг тайлагнахдаа хэрэгжүүлсэн үйл ажиллагаа буюу юу хийснээ тоочсон хэлбэр давамгай, харин үр нөлөө буюу шалгуур үзүүлэлтийн түвшин яаж эергээр өөрчлөгдсөн талаар тодорхой бус байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2025 онд мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Үүнд:

- Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо болон Ноос, ноолуур үйлдвэрлэгчдийн холбоо, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-тэй 2025 оны 03 дугаар сард хамтран ажиллах санамж бичиг байгуулан, хоршоодод мэргэжлийн сургалт, хэлэлцүүлгийг үе шаттайгаар хийж, малын арьс ширний анхан шатны боловсруулалтыг стандартын дагуу бэлтгэн зах зээлд нийлүүлэх, биржийн арилжаанд оролцох сургалт, хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сард зохион байгуулж, нийт 150 хоршоо оролцсон байна.
- “Олон улсын хоршооллын жил-2025” арга хэмжээний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Хөдөө аж ахуйн бирж, Зээлийн батлан даалтын сантай хамтран хоршоодын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээг 2025 оны 10 дугаар сард Арвайхээр суманд зохион байгуулсан байна. Тус арга хэмжээнд 21 аймгийн болон сумдын мэргэжилтнүүд, хоршоодын төлөөлөл оролцож, Есөнзүйл, Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж буй 6 хоршооны туршлага судалсан бөгөөд Арьс, ирээдүй, Ноос ирээдүй ХХК-ий үйл ажиллагаатай танилцан, түүхий эдийг чанар стандартын дагуу бэлтгэх, чанарыг сайжруулах, үндэсний үйлдвэрлэлээ дэмжихэд малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийсэн байна.

Мөн аймгийн хэмжээнд хоршоонд чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэрүүдээс Хоршоо хөгжүүлэх сангийн 2018-2025 оны идэвхтэй зээлийн тоо 234 ба 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт зээлийн үлдэгдэл 3,578.4 сая төгрөг байна.

Түүнчлэн Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн үлдэгдэл 2,672.5 сая төгрөг байгаа нь сангийн зорилт болох хоршоодоор дамжуулан ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг өсгөх, амьжиргааг дэмжих болон орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлд бодит үр дүн гаргахад хангалтгүй байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн 2024-2025 оны зээлийн олголт бага хувьтай байгаа нь хоршоод тавигдах шаардлага, шалгуурыг хангаж чадахгүй байгаа, мөн “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлсэн нь тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Монголбанк, Зээлийн батлан даалтын сан, Арилжааны банк хамтран байгуулсан 2024 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 240509/84, 240508/03-372, 1824/173 дугаар “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулсан байна.

Тус гэрээ нь уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, малчны хамтын санаачилга, хоршоог дэмжих хүрээнд “Хоршооны гишүүн малчны зээл”-ийг банкны эх үүсвэрт тулгуурлан олгох, уг зээлд хамрагдсан малчдад Засгийн газраас зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх болон Зээлийн батлан даалт гаргахтай холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулж, эрх, үүргийг тодорхойлох зорилготой байна.

Гэрээнд мал худалдан авах, малын хашаа, хороо, саравч худалдан авах, шинээр байгуулах, засварлах тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл худалдан авах, шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах зэрэг зориулалтаар зээл олгохоор тусгасан бөгөөд дараах 14 чиглэлээс зарим үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулаагүй байна.

Хүснэгт 4. Хоршоодын үйл ажиллагааны чиглэл, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн хөрөнгө оруулалтын чиглэлүүд	Үндсэн чиглэл ¹	Үйл ажиллагааны хөтөлбөр ²	Хөгжлийн төлөвлөгөө ³
2.1.1.1 Бэлчээрт худаг уст цэг гаргах усан хангамж байгуулах;	2.4.1.3	3.2.2.2	***
2.1.1.2 Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах тэжээлийн үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	2.4.2.3	1.2.3.2, 3.2.2.1	2.2.4.2
2.1.1.3 Мал бордох аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	***	***	***
2.1.1.4 Мах сүү цагаан идээ бэлтгэх боловсруулах үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	***	1.2.1.3	2.2.3.1
2.1.1.5 Үржлийн мал худалдан бойжуулах борлуулах;	2.4.1.4	3.2.1.4	***
2.1.1.6 Ноос ноолуур арьс шир бэлтгэх анхан шатны тордолт хийх цэг цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	2.4.3.3, 2.4.3.4	1.2.1.3, 3.3.1.1	2.2.3.1
2.1.1.7 Дотор мах боловсруулах үйлдвэр цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	***	3.3.1.3	2.3.1.2
2.1.1.8 Мал малын гаралтай түүхий эдийн агуулах зоорь хөргүүр байгуулах;	2.4.3.1, 2.4.3.3	***	2.2.3.1
2.1.1.9 Мал төхөөрөх цех үйлдвэр байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	***	3.3.1.5	2.3.1.2
2.1.1.10 Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх;	***	***	***
2.1.1.11 Мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх;	***	***	***
2.1.1.12 Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлэх;	***	***	2.2.3.1
2.1.1.13 Гахай шувуу зөгий цаа буга зэрэг ашиг шимийг нь тогтмол хүртдэг тэжээвэр амьтны аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	***	***	***
2.1.1.14 ХААН гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих өргөтгөх засварлах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл автомашин тоног төхөөрөмж худалдан авах;	***	3.2.3.1	2.2.3.1

¹ Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

² Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

³ Өвөрхангай аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө

Дээрх хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаанаас харахад мал бордох аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх, гахай шувуу зөгий цаа буга зэрэг ашиг шимийг нь тогтмол хүртдэг тэжээвэр амьтны аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх гэсэн хөрөнгө оруулалтын чиглэлүүд тусаагүй бөгөөд орон нутгийн хөгжлийн бодлогод тусгаж, хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, нэмүү өртөг шингээх үйлдвэрлэл, хоршоонд суурилсан бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд орон нутагт үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний дотоодоос хангаж буй хувь болон 100-аас дээш гишүүнчлэлтэй хоршоолсон хуулийн этгээдийн тоо, тэдгээрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эдийн засагт эзлэх хувь хэмжээг шалгуур үзүүлэлтээр тусгаж, холбогдох арга хэмжээний суурь ба хүрэх түвшнийг тодорхойлж, төлөвлөх шаардлагатай байна.

1.1.3. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий салбар дундын уялдааг хангах үндэсний хороо нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо сул байна.

"Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоолын хүрээнд хэрэгжүүлэх "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэхээр мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, оролцогчдыг уялдаа, зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүргийг "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Хурдасгуур төв"-д хариуцуулж, шаардагдах нэмэлт зардлыг Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар санхүүжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасан байна.

Засгийн газрын 2024 оны "Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, "Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 95 дугаар тогтоолын 42 дугаар хавсралтаар "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг орон тооны хязгаар 15 байхаар шинэчлэн, үндэсний хорооны даргаар Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) байхаар баталжээ.

Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, Үндэсний хорооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталжээ.

Хүснэгт 5. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл

1	Шинэ хоршоо хөдөлгөөнийг малчид, олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг тогтмолжуулах
2	Малчдыг хоршиж, хамтран ажиллах санаачилгыг дэмжих
3	Хоршоодыг чадавхжуулж, зөвлөн туслэх үйлчилгээ үзүүлэн, жишиг хоршоо хөгжүүлэх, гадны орны туршлага
4	Хоршоодыг дотоодын болон гадаадын зах зээлтэй холбох, жишиг стандарт нэвтрүүлэх, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан ханган нийлүүлэлтийн сүлжээг кластераар хөгжүүлэх
5	Төсөв болон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон улсын болон дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татах
6	Зээл авсан хоршоодын санхүүгийн хяналт, ил тод байдлыг сайжруулах, зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах
7	Хамтын удирдлагын байгууллагыг бэхжүүлэх, засаглалыг хөгжүүлэх
8	Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Эх сурвалж: Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолын 1-р хавсралт

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эрчимжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд орон нутагт дараах ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Хоршоодыг чадавхжуулах сургалт зохион байгуулах;
- Жишиг хоршоо хөгжүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;
- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа, зээл авсан хоршоодын төслийн үр дүнг үнэлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;
- Зээлд хамрагдсан хоршоодын санхүүгийн хяналт, ил тод байдлыг сайжруулах;

Аймгийн ХХААГ-аас хоршоодод тулгамдаж байгаа нийтлэг асуудлуудыг дараах байдлаар гаргасан байна.

- Хоршооны зарчмаар ажиллаж чадахгүй байгаа;
- Санхүүгийн хувьд бэхжээгүй /хөрөнгө нийлүүлэх, ашиг хуваах/;
- Гишүүдийн жигд оролцоо, идэвх санаачилга сул ;
- Харилцан итгэлцэл байхгүй /түүхий эдээ хамтран бэлтгэх, борлуулах, нэгдэх гэх мэт/;
- Хуулийн дагуу санхүү, татварын тайлан гаргах чадвар хангалтгүй;
- Хүний нөөцийн дутагдалтай, насжилт ахимаг;
- Сургалт, арга зүйн дэмжлэг авахдаа хойрго ханддаг;

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоол, 2005 оны 01 дүгээр тогтоолуудаар байгууллагын 2024, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцах болон хамтран хэрэгжүүлэх байгууллагаар аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, ХХААГ-ыг тусгасан боловч орон нутагт хэрэгжүүлэх бодлого, оролцогч талуудын уялдаа хангалтгүй байна.

Түүнчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Монголбанк, Зээлийн батлан даалтын сан, Арилжааны банк хамтран байгуулсан 2024 оны 5 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан 240509/84, 240508/03-372, 1824/173 дугаартай “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ нь банкны эх үүсвэрт тулгуурлан олгох хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хөнгөлөлт, зээлийн батлан даалттай холбоотой талуудын эрх, үүрэг, харилцааг зохицуулж байгаа боловч уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад харилцаа, хяналт, хариуцлага, байгууллагуудын уялдаа холбоог нарийвчлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ нь талуудын үндсэн эрх, үүргийг зохицуулсан боловч хэрэгжилтийн хяналт, байгууллагуудын уялдаа, мэдээлэл солилцоо, үр дүнгийн үнэлгээ болон хариуцлагын зохицуулалт хангалтгүй байна. Тухайлбал:

- Хөнгөлөлттэй зээлийг хоршоонд бус, хоршооны гишүүн малчинд олгосон нь хамтын эдийн засгийг хөгжүүлэх бус хувь хүний хөрөнгө оруулалтыг дэмжсэнээр хоршооны чадавх, хамтын бизнесийг бэхжүүлэх бодлогын зорилгыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй, зээлийн гэрээнд бизнес болон зарцуулалтын төлөвлөгөөтэй байх, түүнийг хамтран хэрэгжүүлэхээр заасан боловч гэрээний заалт бүрэн хангагдаагүй байна.
- Зээл олгох үеийн болон олгосны дараах хяналт, тайлагналын журам нарийвчлан зохицуулагдаагүйгээс зээлийн зориулалтын ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна.
- Үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур дутмаг, зээлээр бий болсон эдийн засаг, нийгмийн үр нөлөөг хэмжих үзүүлэлт тодорхойгүйгээс бодлогын үр ашгийг үнэлэх боломж хязгаарлагдаж байна.

- Ерөнхий гэрээнээс өөр хэрэгжилтийн нарийвчилсан журам, зохицуулалт хангалтгүй тул хууль хэрэглээ харилцан адилгүй болж, эрх зүйн хийдэл үүсэх эрсдэлтэй.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, зөрчил арилгах байгууллага, албан тушаалтны хариуцлага тодорхой бус байгаа тул хариуцлагын тодорхой бус байдал үүсэж байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТАГТ ХАМТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРЧИМ, ХОРШООЛЛЫН АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ИДЭВХЖҮҮЛЭХ, УЛМААР ОЛОН ГИШҮҮНТЭЙ ХОРШООЛСОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ САНХҮҮ, ТАТВАР, ЗЭЭЛИЙН БОДЛОГООР ДЭМЖИХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.


2.1. Хоршоо нь хуульд заасан шаардлагыг ханган шинээр үүсгэн байгуулагдсан боловч засаглал, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

2.1.1. Хоршоог үүсгэн байгуулсан гэрээнд хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан боловч "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ болон холбогдох журамд зээлийн үлдэгдэлтэй хоршоог татан буулгахтай холбоотой хязгаарлалт, зохицуулалт тусгагдаагүй байна.

"Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийн хүрээнд Өвөрхангай аймагт 414 хоршооны 1486 гишүүн малчин хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Аудитаар Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1⁴, 8.2⁵-т заасны дагуу дээрх 414 хоршоог үүсгэн байгуулсан гэрээнд хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан эсэхийг Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн мэдээлэлтэй тулгахад 412 хоршоо буюу 99.5 хувь нь хуульд заасан шаардлагыг тусгасан байна.

Хоршооны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3⁶ дахь заалтын дагуу бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн 2025 онд 2 хоршоог нь татан буулгасан байна.

Дүрслэл 1. Хоршооны зорилго, эрх үүрэг, хариуцлагын мэдээллээ тусгасан эсэх



Эх сурвалж. Улсын бүртгэлийн хэлтсээс ирсэн хоршоодын судалгаа

Хүснэгт 6. Татан буугдсан хоршооны мэдээлэл

	Үржих ирээдүй хоршоо	Ар мандалын булаг хоршоо
Үүсгэн байгуулагдсан огноо	2013-02-25	2021-06-02
Татан буугдсан огноо	2025-12-31	2025-12-31
Нийт гишүүдийн тоо	10	9
Зээл авсан гишүүдийн тоо	1	1
Зээл авсан нийт дүн /сая.төг/	22.0	34.0

Эх сурвалж. Opendatalab.mn, Хаан банкнаас ирүүлсэн судалгаа

⁴ 8.1.Хоршоог үүсгэн байгуулагчид хоршоо үүсгэн байгуулах талаар гэрээ байгуулж, уг гэрээнд хоршооны зорилго, үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгана.

⁵ 8.2.Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулах гэрээ дуусгавар болно.

⁶ 47.1.3.хоршоог татан буулгах тухай хоршооны нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй хувь нь санал гаргасан.

Татан буугдсан хоршоодын 2 гишүүний хөнгөлөлттэй зээл нь хоршооны нэр дээр бус малчин иргэний зээлийн мэдээлэлд бүртгэгдсэн тул бусдад өр төлбөртэй талаар мэдээлэл үүсээгүй ба Хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2⁷, 13.3⁸ дахь заалтын дагуу хоршоо татан буугдах үйл явцад малчны авсан зээл нөлөөлөөгүй байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.1.5-д “Гишүүнчлэлтэй хоршоо нь бизнес төлөвлөгөөтэй байх бөгөөд зээлдэгч малчин нь бизнесийн төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх (хариуцлагын) гэрээ байгуулсан байх” гэж заасан байна. Дээрх заалтын дагуу зээл авсан малчин бүр хоршоотой “Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хариуцлагын гэрээ” байгуулсан байна. Мөн зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд зээлдэгч малчны хүлээх хариуцлагыг тусгасан, хоршооны хариуцлагын талаар тусгаагүй байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ болон холбогдох журамд зээлийн үлдэгдэлтэй, гэрээний үүрэг бүрэн дуусаагүй байгаа хоршоог татан буулгахтай холбоотой хязгаарлалт, зохицуулалт тусгагдаагүй байна.

Түүнчлэн хоршоог татан буулгах шийдвэр гаргах үед зээлийн гэрээ, батлан даалт, төрөөс үзүүлсэн хөнгөлөлттэй холбоотой үүргийн хэрэгжилтийг заавал нягтлан шалгах эрх зүйн шаардлага тодорхой бус байгаатай холбоотой эрсдэл үүсэхээр байна. Тухайлбал:

- Хоршоо татан буугдсанаар зээлийн гэрээтэй холбоотой эрх, үүргийн хэрэгжилт тодорхойгүй болж, зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүсэх;
- Зээлийн зориулалтын ашиглалт, хөрөнгө оруулалтын үр дүнд тавих хяналт сулрах;
- Хөдөлгөөний зорилго болох хоршоонд суурилсан хамтын үйл ажиллагаа, хоршооны тогтвортой үйл ажиллагааг дэмжих үр нөлөө буурах;
- Зээлийн эргэн төлөлт хэтрэх, чанаргүй болох тохиолдолд хариуцлага хүлээх этгээдийг тодорхойлох, өр төлбөр барагдуулах ажиллагаанд эрх зүйн маргаан үүсэх;

2.1.2. Хоршооны дүрэмд хоршоог үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.

Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйлд⁹ хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм ба дүрэмд хоршооны гишүүний оруулах хувь хөрөнгө болон заавал оруулах хөрөнгийн хэмжээ, хоршоонд нэмж оруулж болох хувь хөрөнгийн дээд хэмжээ, болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийн хувь хэмжээ, хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хувь хэмжээг тусгахаар заасан байна.

⁷ 13.2.Хоршоо нь хоршооны гишүүний бусдын өмнө хүлээх үүргийг хариуцахгүй.

⁸13.3.Хоршооны гишүүн нь хоршооны хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү хоршоонд оруулсан хувь хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

⁹ 10.1.Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм байна.

10.2.Хоршооны дүрмийг бүх гишүүдийн хурлаар батална.

10.3.Хоршооны дүрэмд дараах асуудлыг тусгана:

Дүрслэл 2. Хоршооны хөрөнгийн төрөл



Эх сурвалж: Хоршооны тухай хууль


Хоршооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т анхан шатны хоршоог ес ба түүнээс дээш иргэн хамтран байгуулж болохоор заасан. “Хоршооны гишүүн малчны зээл”-д хамрагдсан гишүүдтэй 414 хоршооны гишүүдийн бүтцийг авч үзэхэд 399 хоршоо 9-20 гишүүнтэй, 7 хоршоо 21-100 гишүүнтэй, 6 хоршоо 100-500 гишүүнтэй байна.

Мөн хоршоодын дүрэмд тусгасан нийт хөрөнгийн хэмжээгээр ангилбал 362 хоршооны нийт хөрөнгө 5.0 сая төгрөг хүртэл, 25 хоршооны нийт хөрөнгө 5.0-10.0 сая төгрөг, 14 хоршооны нийт хөрөнгө 10.0-20.0 сая төгрөг, 11 хоршооны нийт хөрөнгө 20.0-55.0 сая төгрөг байна.

Аудитад хамрагдаж буй хоршоодын 399 нь 9-20 гишүүнтэй буюу нийт хоршооны 96.4 хувийг, хоршооны дүрэмд тусгасан нийт хөрөнгийн хэмжээ 362 хоршооны хувьд 5.0 сая төгрөг хүртэл байгаа нь нийт хоршооны 87.4 хувийг эзэлж байна.

Дээрх 414 хоршоо нь улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхдээ хоршооны дүрэмд нийт хөрөнгийн хэмжээгээ бүрэн тусгасан байна.

Дүрслэл 4. Хоршооны дүрэмд заасан нийт хөрөнгийн хэмжээгээр харуулсан бүтэц




Эх сурвалж: Улсын бүртгэлийн хэлтсээс ирсэн хоршоодын судалгаа

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийн хүрээнд олон хоршоо богино хугацаанд байгуулагдсан, гишүүдийн тоо болон хувь хөрөнгийн хэмжээ харьцангуй бага, санхүүгийн чадавх сул байгааг харуулж байна. Иймээс хоршоодыг зөвхөн зээлд хамруулах бус, хувь хөрөнгийг нэмэгдүүлэх, гишүүдийн оролцоо, хамтын үйлдвэрлэл, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аудитаар дээрх хоршоодын хоршооны нэг гишүүний заавал оруулах хөрөнгийн хэмжээг тулган баталгаажуулахад 32 хоршоо нэг гишүүний заавал оруулах хөрөнгийн хэмжээг дүрэмд тусгаагүй, 5 хоршоо мал оролцуулахаар тооцож хоршооны дүрэмд тусган бүртгүүлсэн байна. Хоршооны нэг гишүүний заавал оруулах хөрөнгийн хэмжээг 377 хоршооны дүрэмд 5.0-5,000.0 мянган төгрөгөөр тусгасан байна.

Дүрслэл 3. Хоршооны заавал байршуулах хөрөнгө



Үүнээс хоршооны дүрэмд заасан нийт хөрөнгийн хэмжээ болон заавал байршуулах хөрөнгийн хэмжээтэй таарч байгаа хоршоо 203, таарахгүй байгаа 174 үүнээс хоршооны дүрэмд заасан нийт хөрөнгийн хэмжээ заавал байршуулах хөрөнгийн нийт дүнгээс их 128, бага 46 хоршоо байна. Хоршооны дүрэмд заасан нийт хөрөнгийн хэмжээ заавал байршуулах хөрөнгийн нийт дүнгээс их буюу тэнцүү байхаар тусгасан байна.

2.1.3. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 96.6 хувь нь хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг байршуулаагүй байна.

Хоршооны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, хоршооны дүрмийн 32.1-д “Хоршооны хөгжил, гишүүдийн нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор хоршоо хөгжлийн сантай байж болно” гэж заасан.

Хөгжлийн сантай 12 хоршооны 4 нь 2024 онд хөгжлийн сангийн дансандаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан боловч 2025 оны санхүүгийн тайланг ирүүлээгүй байна. Харин тайлан ирүүлсэн 8 хоршооны хөгжлийн сангийн дансны үлдэгдэл нийт 21,107.3 мянган төгрөг байгаа нь нийт хоршоодын 1.9 хувийг эзэлж байна. Хөгжлийн сантай хоршооны нэр, хөрөнгийн хэмжээг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7. Хоршооны хөгжлийн санд байршуулсан хөрөнгө /төгрөг/

№	Хоршооны нэр	Мөнгөн дүн
1	Түмний буян далай хоршоо	11,534,000
2	Арвин хуст хоршоо	6,000,000
3	Есөн угалз хоршоо	1,350,000
4	Харцагт хад хоршоо	1,000,000
5	Баруун голынхон хоршоо	800,000
6	Алтаннуга даваа хоршоо	273,300
7	Гэгээн онгийн нэгдэл үргэлжлэл хоршоо	100,000
8	Сүмбэр ноён хайрхан хоршоо	50,000
Нийт		21,107,300

Эндээс дүгнэхэд нийт 414 хоршооны 96.6 хувь нь хөгжлийн сан байгуулаагүй байгаа нь Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасан хөгжлийн сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулахтай холбоотой үйл ажиллагааг хангалттай хэрэгжүүлээгүй байгааг харуулж байна.

Хөгжлийн сантай хоршоодоос зарим нь тайлангаа ирүүлээгүй байгаа нь хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналд тавих хяналт хангалтгүй байгааг илэрхийлж байна. Иймд хөгжлийн сан байгуулах, хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах журам батлах, тайлагналыг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.1.4. Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийг бүрдүүлээгүй байна.

Хоршооны тухай хуулийн 4.1.6. "болзошгүй эрсдэлээс хамгаалах сан" гэж хоршоонд учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор энэ хууль болон хоршооны дүрэмд заасны дагуу хоршооны борлуулалтын орлогоос хуримтлуулах мөнгөн хөрөнгийг; 10.3.20. болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийн хувь хэмжээ, уг санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ; 25.1.Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна, 25.4. Болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ нь хоршооны сүүлийн гурван жилийн борлуулалтын орлогын дунджийн 20 хувиас хэтрэхгүй байхаар гэж тус тус заасан байна.

Түүнчлэн хоршооны дүрмийн 31.1-д "Хоршоо заавал болзошгүй эрсдэлээс хамгаалах сан байгуулж ажиллана", 31.2-т "Хоршоо тухайн жилийн борлуулалтын нийт орлогоос 20.0 хүртэлх хувиар болзошгүй эрсдэлээс хамгаалах санг байгуулна" гэж заажээ.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 414 хоршооноос зөвхөн 1 хоршоо буюу 0.24 хувь нь болзошгүй эрсдэлээс хамгаалах санд 7,882.8 мянган төгрөг төвлөрүүлсэн бөгөөд үлдсэн 413 хоршоо нь тус санд хөрөнгө хуримтлуулаагүй байна. Иймээс ихэнх хоршоо Хоршооны тухай хууль болон өөрийн дүрэмд заасан болзошгүй эрсдэлээс хамгаалах сантай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлээгүй байна.

Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын үйл ажиллагаа 2024 оны 6 дугаар сараас 2025 оны 01 дүгээр сарын хооронд эхэлсэн бөгөөд анхан шатандаа байна. Үүнтэй холбоотойгоор хоршоодын санхүүгийн чадавх, дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын механизм бүрэн төлөвшөөгүй бөгөөд 414 хоршооноос зөвхөн 1 хоршоо болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлсэн бол бусад хоршоод тус санг бүрдүүлээгүй байна. Энэ нь хоршоодын хувьд эрсдэлийг удирдах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээ хангалтгүй байгааг харуулж байна.


Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийт хоршоо нь ихэвчлэн үйл ажиллагааны анхан шатандаа байгаа бөгөөд санхүүгийн удирдлага, бүртгэл тайлагнал, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. Иймээс болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь хоршоодын хөгжлийн үе шат, менежментийн чадавхтай холбоотой байна.

2.1.5. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршооны 51.4 хувь нь санхүүгийн тайлан гаргаж, бүртгэл хөтлөөгүй байна.

Сангийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/155 дугаар тушаалаар батлагдсан "Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам", "Хоршооны санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоод нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа хугацаанд нь гарган тайлагнах үүрэгтэй.

Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийт 414 хоршооны 213 хоршоо буюу 51.4 хувь нь 2025 онд санхүүгийн тайлангаа системд илгээгээгүй, нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, 201 хоршоо буюу 48.6 хувь нь холбогдох хууль, журам, зааварт заасны дагуу санхүүгийн тайлан гаргаж, бүртгэл хөтөлсөн байна. Үүнээс 15.9 хувь буюу 66 хоршоо нь ашиг, алдагдлаа тооцон санхүүгийн тайлангаа бүрэн гаргасан ба 135 хоршоо нь Х-тайлан тайлан илгээсэн байна.

Дүрслэл 5. Хоршоодын санхүүгийн тайлан илгээсэн мэдээлэл



Эх сурвалж: СТСХ-ээс ирүүлсэн судалгаа

Татварын тайлангаар 414 хоршооноос 2024 онд 339 буюу 81.9 хувь нь, 2025 онд 375 буюу 90.6 хувь нь татварын тайлан илгээсэн байна. Татварын тайлан илгээлтийн хувь өмнөх оноос 8.7 нэгж хувиар өссөн эерэг үзүүлэлттэй. Харин нийгмийн даатгалын шимтгэл төлөлт нийт хоршооноос 2024 онд 11 буюу 2.7 хувь нь, 2025 онд 13 буюу 3.1 хувь нь НДШ-ийн тайлан гаргасан байна.

Хүснэгт 8. Хоршоодын татвар, НДШ-ийн тайлан гаргасан байдал

Тайлангийн төрөл	2024 он		2025 он	
	Тайлан гаргасан хоршоо	Нийт хоршоонд эзлэх хувь	Тайлан гаргасан хоршоо	Нийт хоршоонд эзлэх хувь
Татварын тайлан	339	81.9	375	90.6
НДШ-ийн тайлан	11	2.7	13	3.1

Эх сурвалж: Татвар, НД-ын байгууллагаас ирүүлсэн судалгаа

Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 90.6 хувь нь татварын тайланг хуулийн хугацаанд илгээсэн боловч нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн хувьд хангалтгүй ба нийт хоршооны 3.0 хувь нь тайлан илгээсэн байна. Эндээс харахад хоршоодын удирдлага, гишүүдийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдлэг, ур чадвар хангалтгүй, тайлан гаргах мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байгаа нь санхүүгийн тайлан, бүртгэлийг хуульд заасны дагуу хөтлөх боломжийг хязгаарлаж байна. Мөн хоршоодод үзүүлэх мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг хангалтгүй байгаагаас тайлагналын сахилга хариуцлага сул байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс Улсын бүртгэлийн хэлтэст шинээр бүртгэгдсэн хоршоодын мэдээлэл авах хүсэлтийг хүргүүлдэг боловч тухайн мэдээллийг "Прокурорын зөвшөөрөл"-өөр олгоно гэсэн тайлбарын улмаас шаардлагатай мэдээллийг авч чаддаггүй байна.

Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалт, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл дамжуулах журам, уялдаа холбоо хангалтгүйгээс анхан шатны бүртгэлийн мэдээллийг шуурхай авах боломж хязгаарлагдсан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1¹⁰-т зааснаар санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй, идэвхгүй төлөвт шилжсэн ААН-ийн жагсаалтыг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлдэг бөгөөд үүний дагуу орон нутгийн өөрийн цахим хуудсаар нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш 6 сарын дотор

¹⁰ 26.1.Санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага өөрийн цахим хуудсаар нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр санал, гомдол гаргаагүй, дампуурлын хэрэг үүсгээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй бол уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна.

бичгээр, эсхүл цахим хэлбэрээр санал, гомдол гаргаагүй, дампуурлын хэрэг үүсгээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй бол уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах зохицуулалттай байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийт 414 хоршооны 213 хоршоо /Хавсралт 1/ буюу 51.4 хувь нь 2025 онд санхүүгийн тайлангаа системд илгээгээгүй, нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй байна.

Хоршоодын 51.4 хувь нь санхүүгийн тайлан гаргаж, нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹¹, 14 дүгээр зүйлийн 14.1¹²-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй, хоршоодын санхүүгийн чадавх сул, санхүү, татварын тайлан гаргах мэдлэг, ур чадвар дутмаг байгаа нь хоршооны үйл ажиллагааны тогтвортой байдал, хариуцлагатай тайлагналд сөргөөр нөлөөлж байна.

2.2. Хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хэвийн боловч зээл олгох шалгуур, зориулалтын ашиглалт, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.

2.2.1. Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй гэрээний зохицуулалт хангалтгүй, зарим зээлдэгч зээл хүсэгчид тавигдах шаардлагыг хангаагүй байна.

Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөө, “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох санхүүжилтийн эх үүсвэрийг арилжааны банкны эх үүсвэрээс бүрдүүлэхээр зохицуулсан бөгөөд зээлийн гэрээний нөхцөлүүдийг дараах байдлаар тусгасан байна.

<i>Хүснэгт 9. “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн гэрээний нөхцөлөөс...</i>	
Зээлийн зориулалт:	Мал худалдан авах, малын хашаа, хороо, саравч худалдан авах, шинээр байгуулах, засварлах тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл худалдан авах, шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах зэрэг гэрээнд заасан 14 чиглэл
Нэг зээлдэгчид олгох хэмжээ:	50 сая төгрөг хүртэлх;
Зээлийн нийт хүү:	18.0 хувиас хэтрэхгүй;
Зээлийн хүүгийн хөнгөлөлтийн хэмжээ:	12.0 хувь;
Зээлийн хугацаа:	5 жил хүртэл;
Зээлийн шимтгэл, хураамж:	Банкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлөөр, ижил төрлийн зээлийн бүтээгдэхүүний шимтгэл, хураамжаас ихгүй байх;
Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа:	Зээлдэгчийн орлоготой уялдуулан банк зээлдэгчтэй хамтран тогтоох бөгөөд 12 сараас хэтрэхгүй;
Зээлийн барьцаа хөрөнгөд тавигдах шаардлага:	Банкны өөрийн дотоод журмын дагуу зохицуулагдана. Банк болон Зээлийн батлан даалтын сан зээлээр бий болгох хөрөнгийг нөхөж барьцаалж болно;
Зээлийн батлан даалтын хувь хэмжээ	20.0 сая төгрөг ба түүнээс доош дүнтэй зээлд 100 хүртэл хувь, 20 сая төгрөгөөс 40.0 сая төгрөгийн дүнтэй зээлд 90 хүртэл хувь, 40.0 сая төгрөг ба түүнээс дээш дүнтэй зээлд 80 хүртэл хувь;

Эх сурвалж: “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ

¹¹ 9.1.Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй.

¹² 14.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

Түүнчлэн хөнгөлөлттэй зээл хүсэгч нь дараах шаардлагуудыг хангасан байх бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг санхүүжилтийн ерөнхий гэрээгээр тодорхойлсон байна.

Хүснэгт 10. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн гэрээний зээл хүсэгчид тавигдах шаардлага.

Зээл хүсэгчид тавигдах шаардлага	Шаардлага хангаж байгаа эсэхийг нотлох баримт бичиг, лавлагаа
Зээл хүсэгч нь хоршооны гишүүн малчин байх	Улсын бүртгэлийн гэрчилгээ, төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia/-ийн "Малчны тодорхойлолт"-оор тодорхойлно.
Үндсэн зээлдэгчийн нэр дээр мал тооллогод хамрагдсан байх	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia/-ийн "Мал тооллогын бүртгэл"-ийн лавлагаагаар тодорхойлно.
Хоршооны үйл ажиллагаа эрхлэх хот, аймагт оршин суудаг байх	Оршин сууж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тодорхойлолтоор тодорхойлно.
Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өр төлбөрийн үлдэгдэлгүй байх	---
Гишүүнчлэлтэй хоршоо нь бизнес төлөвлөгөөтэй байх бөгөөд зээлдэгч нь бизнес төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх гэрээг хэрэгжүүлэгч талуудтай байгуулсан байх	Үндсэн зээлдэгчийн гишүүнчлэл бүхий хоршооны хэрэгжүүлэх төслийн дүн нь 100 сая төгрөг ба түүнээс доош дүнтэй байх тохиолдолд бизнес төлөвлөгөөтэй байх шаардлагагүй бөгөөд зээлийн зориулалтыг хангасан зарцуулалтын төлөвлөгөөтэй байх, бусад гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх гэрээг байгуулсан байна.
Суурин барилга, байгууламж барих, өргөтгөх зориулалтаар хүсэлт гаргасан зээл хүсэгч нь өөрийн эсхүл хоршоо, хоршооны бусад гишүүдийн нэр дээр өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй газартай байх	Суурин барилга, байгууламж барих, өргөтгөхөөс бусад зориулалтаар зээл хүсэхэд уг шаардлага хамаарахгүй.
Банкнаас зээлийн үйл ажиллагаатай холбоотой журам, зааврын хүрээнд тавигдах бусад холбогдох шаардлага	---

Эх сурвалж: "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ

Өвөрхангай аймагт "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд 2024-2025 онд дараах 3 арилжааны банкны эх үүсвэрээр нийт 414 хоршооны 1486 малчин хоршоологч 51,253.3 сая төгрөгийн зээлд хамрагдсан байна.

Хүснэгт 11. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн мэдээ /сая төгрөгөөр/

№	Банкны нэр	Хоршооны тоо	Малчны тоо	Олгосон зээлийн дүн
1	Хаан банк	213	652	21,151.0
2	Төрийн банк	200	828	29,917.2
3	Хас банк	1	6	185.1
Нийт		414	1,486	51,253.3

Эх сурвалж: Монголбанкны зээлийн мэдээллийн сан

Тус хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийг зориулалтаар нь ангилж үзэхэд 70.7 хувь нь үржлийн мал худалдан бойжуулах, борлуулах чиглэлээр 36,248.9 сая төгрөгийн зээл олгосон байх бөгөөд холбогдох мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 12. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн зориулалтаар ангилсан үзүүлэлт /сая төгрөгөөр/

№	Зээлийн зориулалт	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн
1	Бэлчээрт худаг уст цэг гаргах усан хангамж байгуулах;	41	1,350.0
2	Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах тэжээлийн үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	68	2,692.0
3	Мал бордох аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	4	108.0
4	Мах сүү цагаан идээ бэлтгэх боловсруулах үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	134	3,934.0


5	Үржлийн мал худалдан бойжуулах борлуулах;	1,036	36,248.9
6	Ноос ноолуур арьс шир бэлтгэх анхан шатны тордолт хийх цэг цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	3	90.0
7	Дотор мах боловсруулах үйлдвэр цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	-	-
8	Мал малын гаралтай түүхий эдийн агуулах зоорь хөргүүр байгуулах;	30	925.0
9	Мал төхөөрөх цех үйлдвэр байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	4	120.0
10	Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх;	7	229.0
11	Мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх;	3	120.0
12	Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлэх;	23	780.4
13	Гахай шувуу зөгий цаа буга зэрэг ашиг шимийг нь тогтмол хүртдэг тэжээвэр амьтны аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх;	-	-
14	ХААН гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих өргөтгөх засварлах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл автомашин тоног төхөөрөмж худалдан авах;	123	4,414.0

Эх сурвалж: Монголбанкны зээлийн мэдээллийн сан

Хүснэгтээс харахад нийт олгосон зээлийн дийлэнхийг үржлийн мал худалдан авах, бойжуулах, борлуулах зориулалтаар олгосон нь санхүүжилт нэг чиглэлд төвлөрснийг харуулж байгаа тул уг чиглэлээр олгосон зээлийн зориулалтын ашиглалт, хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй тохиолдолд зээлийг зориулалт бусаар ашиглах, улмаар хөтөлбөрийн зорилго, үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Зээлдэгчдийг зээлийн хэмжээгээр нь ангилан харуулбал:

Дүрслэл 6. Зээлдэгчдийг зээлийн хэмжээгээр бүлэглэсэн тоон үзүүлэлт



Эх сурвалж: Эх сурвалж: Монголбанкны зээлийн мэдээллийн сан

- Дээрх тоон мэдээллээс харахад нийт олгосон зээлийн дүнгийн 62.8 хувь нь 40.0–50.0 сая төгрөгийн зээл авсан байгаа нь зээлдэгчдийн дийлэнх хувь байна.

Хөнгөлөлтэй зээлд хамрагдсан малчдыг мал тооллогын 2023-2025 оны дүнгээр малын тоогоор нь бүлэглэж авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 13. Зээлдэгчдийг малын тоогоор бүлэглэсэн тоон үзүүлэлт

Малын тооны бүлэг	Малчны тоо			Нэг малчинд ногдох малын тоо		
	2023	2024	2025	2023	2024	2025
50 хүртэлх малтай	39	31	47	36	37	35
51-200	359	319	403	138	138	135
201-500	666	627	576	325	331	324
501-1000	289	350	322	667	693	687
1001-2000	115	136	110	1,171	1,186	1,194
2001-ээс дээш малтай	2	5	3	2,337	2,188	2,422

Эх сурвалж: Статистикийн хэлтсээс ирсэн мэдээлэл

- Нийт зээлдэгчдийг малын тоогоор ангилбал 201–500 толгой малтай малчид 2023-2025 онд хамгийн олон буюу 576-666 малчин байгаа бөгөөд нийт зээлдэгчдийн үндсэн хэсгийг бүрдүүлж байна.
- Харин 1001-ээс дээш толгой малтай малчдын тоо харьцангуй цөөн, жилд 113-141 орчим боловч эдгээр нь үйлдвэрлэлийн цар хүрээ, хөрөнгө оруулалтын хэрэгцээ өндөр байх магадлалтай байна.

Хөнгөлөлттэй зээлийн дийлэнх нь 40.0–50.0 сая төгрөгийн ангилалд олгогдсон бол зээлдэгчдийн ихэнх нь 201–500 толгой малтай малчид байна. Иймд зээл хүсэгч малчны хөрөнгө оруулалтын хэрэгцээ, төсөл, эргэн төлөх чадвар болон үйлдвэрлэлийн хүчин чадлыг бодитой үнэлж, зээлийн хэмжээг эдгээр шалгуур болон малын тоотой уялдуулан тогтоох, өндөр дүнтэй зээлийн шийдвэрийн үндэслэлд тавих хяналтыг сайжруулж, зорилтот бүлэгт чиглэсэн санхүүжилтийн үр нөлөөг тогтмол үнэлэх шаардлагатай байна.

Өвөрхангай аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2023-2025 дундаж үзүүлэлтээр нийт малтай өрх 20,000, малчин өрхийн тоо 18,263, мал бүхий өрхийн тоо 1,737 байна. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан малчдын тоо, малчин өрхийн тоог сумдаар харьцуулбал:

Хүснэгт 14. Өвөрхангай аймгийн малчин өрх, зээлдэгчийн тоон үзүүлэлтүүд

№	Сум	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Мал бүхий өрхийн тоо	Зээлдэгчийн тоо	Малчин өрхийн тоонд эзлэх хувь
1	Арвайхээр	1,645	1,223	422	76	6.2
2	Баруунбаян-Улаан	559	516	43	20	3.9
3	Бат-Өлзий	1,684	1,602	82	110	6.9
4	Баянгол	924	857	67	133	15.5
5	Баян-Өндөр	1,029	938	91	88	9.4
6	Богд	1,234	1,156	79	43	3.7
7	Бүрд	728	663	65	29	4.4
8	Гучин-Ус	531	465	66	38	8.2
9	Есөнзүйл	763	721	41	13	1.8
10	Зүүнбаян-Улаан	1,270	1,245	25	320	25.7
11	Нарийнтээл	752	608	144	11	1.8
12	Өлзийт	682	655	28	12	1.8
13	Сант	948	893	55	86	9.6
14	Тарагт	1,030	1,008	22	83	8.2
15	Төгрөг	668	644	24	62	9.6
16	Уянга	2,020	1,915	105	179	9.3
17	Хайрхандулаан	920	762	159	25	3.3
18	Хархорин	1,247	1,141	106	105	9.2
19	Хужирт	1,364	1,253	111	53	4.2
	Нийт	20,000	18,263	1,737	1486	8.1

Эх сурвалж: Монгол банкны мэдээллийн сан, uvurkhanga.nso.mn

Дээрх хүснэгтээс харахад зээлдэгчдийн малчин өрхийн тоонд эзлэх хувиар Зүүнбаян-Улаан, Баянгол, Сант, Төгрөг сумд хамгийн өндөр үзүүлэлттэй ба Есөнзүйл, Нарийнтээл, Өлзийт сумд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хөнгөлөлттэй зээлд хамрагдалт багатай байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-д хамрагдсан 8 иргэн “Хоршоо хөгжүүлэх сан”-аас нийт 280.0 сая төгрөгийн зээл авсан бөгөөд 25.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 3 иргэн явцын хугацаа хэтэрсэн зээлтэй, 1 иргэний зээлийн гэрээний хугацаа дууссан боловч зээлээ бүрэн төлөөгүй байна.

Түүнчлэн “Хоршооны гишүүн малчны зээл”-д хамрагдсан 13 хоршоо “Хоршоо хөгжүүлэх сан”-д 706.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас 2 хоршоо нь 14.1 сая төгрөгийн зээл явцын хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь өмнөх зээлийн үүргээ бүрэн биелүүлээгүй, хугацаа хэтэрсэн зээлтэй иргэн, хоршоод дахин хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нь зээлийн эргэн төлөлт муудах, чанаргүй зээл үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2026 оны 6 сарын байдлаар 4 суманд нийт 106.8 га газрыг 25 хоршоонд Газрын тухай хуулийн дагуу газрын цахим биржээр зарлан, сонгон шалгаруулж эзэмшүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 15. Хоршоонд эзэмшүүлсэн газрын мэдээлэл

№	Сумын нэр	Хоршооны тоо	Газрын хэмжээ /га/
1	Хархорин	8	40
2	Уянга	12	46.3
3	Арвайхээр	3	10.5
4	Бүрд	2	10
Нийт		25	106.8


Эх сурвалж: ГХБХБГ-аас ирүүлсэн мэдээлэл

Зээлийн батлан даалтын сан нь “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 7.8.2-т зээлдэгчийн төлөх батлан даалтын сангийн шимтгэлээр эрсдэлийн сан бүрдүүлэх үүргийг хүлээсэн байна.

Зээлийн батлан даалтын сан	Зээлийн батлан даалтын сангаас 639 зээлдэгчийн 23,138.8 сая төгрөгийн зээлд 14,889.4 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.
Зээлийн батлан даалтын шимтгэл	2024-2025 онд нийт 466.7 сая төгрөгийн зээлийн батлан даалтын шимтгэл төлж эрсдэлийн нөөц сан бүрдүүлсэн байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн зээлийн гэрээнд зээлийн батлан даалтын хэмжээг 20.0 сая төгрөг хүртэлх зээлд 100 хүртэл хувь, 20.0–40.0 сая төгрөгийн зээлд 90 хүртэл хувь, 40.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлд 80 хүртэл хувь байхаар тогтоосон бөгөөд уг зохицуулалтын дагуу зээлийн батлан даалтыг дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

Дүрслэл 7. Зээлдэгчийг зээлийн батлан даалтын хувиар бүлэглэсэн тоон үзүүлэлт



Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сангаас ирүүлсэн мэдээлэл

Зээлийн батлан даалт хэрэгжсэнээр барьцаа хөрөнгийн дутагдалтай ч бизнесийн хувьд хэрэгжих боломжтой төсөл, үйл ажиллагааг санхүүжилтэд хамруулах нөхцөл бүрдэж, хоршооны гишүүн малчны хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломж нэмэгдсэн байна.

“Шинэ хоршоо хөдөлгөөн” нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор хэрэгжиж байгаа бөгөөд “Хоршооны гишүүн малчны зээл” нь арилжааны банкны эх үүсвэрт тулгуурлан олгогдож, Засгийн газраас зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх, шаардлагатай тохиолдолд зээлийн батлан даалт гаргах замаар малчдын хөрөнгө оруулалтын хэрэгцээг санхүүжүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл юм.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.1.1¹³-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia/-ийн “Малчны тодорхойлолт”-оор тодорхойлохоор заасан боловч тус системээс лавлагаа, мэдээлэл авахад малчин, мал бүхий иргэнд адил “Малчны тодорхойлолт” гарч байгаа тул малчныг тодорхойлох нотлох эсэх нь эргэлзээтэй нөхцөл байдал үүсэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “малчин гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг”, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “мал бүхий этгээд гэж 3.1.2¹⁴-т зааснаас бусад малыг өмчилж байгаа этгээдийг” гэж тус тус заасан байна.

Аймгийн НДГ-аас 1486 зээлдэгчийн 2023-2025 онд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн судалгааг даатгуулагчийн төрлөөр авахад 111 иргэн хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа үндсэн ажилтан, иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагч, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан зэрэг төрөл кодоор шимтгэл төлж байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн “Малчны тодорхойлолт” нь малчин болон мал бүхий иргэнийг ялган тодорхойлох боломжгүй байгаа нь зээл хүсэгчийн шалгуур шаардлагыг үнэн зөв тодорхойлоход эрсдэл үүсгэж, шаардлага хангаагүй этгээдэд хөнгөлөлттэй зээл олгогдох нөхцөлийг бүрдүүлсэн тул 111 мал бүхий иргэнд нийт 3,583.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн 2024 оны 240509/84, 240508/03-372, 1824/173 дугаар ерөнхий гэрээнд шаардлага хангаагүй зээлдэгчдэд олгосон зээлийн гэрээг цуцлах, зээлийг эргэн төлүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авах эрхзүйн зохицуулалт тодорхойгүй байгаа тул Үндэсний аудитын газарт шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад уламжлах санал хүргүүлээ.

2.2.2. Зээлдэгчдийн зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хэвийн төлөгдөж, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын дагуу 2024, 2025 онуудад нийт 414 хоршооны 1486 малчинд 51,253.3 сая төгрөгийн зээлийг арилжааны банкнуудаар дамжуулан олгосноос 2026 оны 3 дугаар сарын 31-ны байдлаар 1470 зээлдэгчийн зээлийн эргэн төлөлт арилжааны банкнуудтай байгуулсан гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн төлөгдөж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлүүдээс хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл байхгүй, зээлийн багцын чанар сайн байна. Төлбөл зохих зээлийн дүн 13,428.87 сая төгрөг байснаас 13,910.67 сая төгрөгийг төлсөн буюу 481.80 сая төгрөгийн илүү төлөлттэй байна.

¹³ 3.1.1.Зээл хүсэгч нь хоршооны гишүүн малчин байх;

¹⁴ 3.1.2."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;

Өвөрхангай аймгийн хувьд 2026 онд нийт нутгаар өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүнд байсан боловч малчид санхүүгийн сахилга батыг өндөр түвшинд сахиж зээл төлөлт хэвийн байна. Малчид малаа эдийн засгийн эргэлтэд оруулах, ноос ноолуур болон малын бусад түүхий эдийн борлуулалтын орлогоороо зээлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байгаа нь тогтоогдсон.

Харин 16 зээлдэгч 399.47 сая төгрөгийн зээлээ дараах шалтгаанаар урьдчилж хаасан байна.

- Монгол банкны 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн шалгалтаар Төрийн банкнаас 50.0 сая төгрөгийн зээл авсан нэг зээлдэгч зээлээ зориулалт бусаар ашигласан нь тогтоогдсон байна. Улмаар тус зээлийг хаалгах тухай актын дагуу зээлийг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хаалгасан байна.
- Төрийн банкны дотоод аудитын шалгалтаар 1 зээлдэгчийн 20.0 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар ашигласан зөрчил илэрчээ. Үүний дагуу тавьсан актын дагуу зээлийг хугацаанаас нь өмнө буцаан дуудаж, бүрэн хаалгасан байна.
- Бусад 14 зээлдэгч нь 311.1 сая төгрөгийн зээлээ өөрийн хүсэлтээр хугацаанаас өмнө урьдчилж хаасан байна.

Хүснэгт 16. Хаагдсан зээлийн хэмжээ банкаар, /сая төгрөгөөр/

№	Банкны нэр	Зээлдэгчийн тоо	Олгосон зээлийн дүн	Зээл хаасан дүн 2026.03.31
1	Хаан банк	12	282.5	294.0
2	Төрийн банк	3	82.0	88.2
3	Хас банк	1	16.6	17.3
Нийт дүн		16	381.1	399.5

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

"Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний хүрээнд Өвөрхангай аймагт хэрэгжиж буй хөнгөлөлттэй зээлийн төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, малчдын орлогыг дэмжих зорилгоо биелүүлж байна. Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал тулгарсан хэдий ч малчдын түүхий эд, мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлого нь зээлээ хугацаанд нь төлөх үндсэн хөшүүрэг болж чадсан байна. Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу найдвартай хийгдэж байгаа бөгөөд санхүүгийн ямар нэгэн эрсдэл үүсээгүй байна.

2.2.3. Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбар, Зээлийн батлан даалтын сан, арилжааны банк нь гэрээний үүргээ биелүүлээгүй, зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг хангалтгүй байна.

"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд зээлийн ашиглалт, зарцуулалтад тавих талуудын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж харилцааг зохицуулсан.

8.1. Банкны дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж

"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн ашиглалт, зарцуулалтад хагас жил хяналт тавьж, дотоод аудитын тайланг хагас жил тутам Монголбанканд хүргүүлнэ.

8.2. Монголбанкны орон нутаг дахь нэгж

"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн ашиглалт, зарцуулалтад зайны хяналт шалгалтыг хийнэ. Хяналт шалгалтыг хийхдээ холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос туслалцаа дэмжлэг авч болно.

8.3. Зээлийн батлан даалтын сан

"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн ашиглалт, зарцуулалтад хяналт шалгалт тавина. Хяналт тавихтай холбоотойгоор төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос туслалцаа дэмжлэг авч болно.

Арилжааны банкны хяналт:

Аудитын түүвэрт хамрагдсан 11,611.7 сая төгрөгийн зээл бүхий 329 гишүүн малчны зээлийн хувийн хэрэгт шалгалт хийж, зээлийн зориулалт, ашиглалтад банкны зүгээс хяналт тавьж ажилласан эсэхийг үзэхэд хяналт хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал:

- Банкны зээлийн эдийн засагч нь зээлийн хувийн хэрэгт зээлийн хяналтын хуудсыг хавсаргасан боловч ихэнх нь зайнаас хяналт хэрэгжүүлсэн, зориулалтын дагуу ашигласан болохыг нотолсон баримт байхгүй;
- Үржлийн мал худалдан авах зориулалтаар зээл авсан зээлдэгчийн хувийн хэрэгт хяналтын нотлох баримт буюу малын А дансны мэдээллийн зөрүүтэй байдлыг баталгаажуулаагүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна;
- “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн 2024 оны 240509/84, 240508/03-372, 1824/173 дугаар ерөнхий гэрээний 8.1¹⁵-д заасны дагуу тайланг Монголбанкны орон нутаг дахь нэгжид ирүүлээгүй;

Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбарын хяналт:

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны А/310 дугаар “Монголбанкны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг шинэчлэн батлах тухай тушаалын хавсралтын 8-д “Банк, зохицуулалттай этгээдэд газар дээрх болон зайнаас тавьсан хяналт шалгалтын танилцуулга, акт материал, дүгнэлт, тайлан”-г баталсан байна. Иймд Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбар болон арилжааны банкнаас “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтын хяналт шалгалтын тайлан, мэдээ хязгаарлагдмал, хяналтыг хэрэгжүүлж ажилласан эсэхэд үнэлгээ өгөхөд хүндрэлтэй байлаа.

Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбар “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд 47 хоршооны 97 гишүүн малчны 3,955.6 сая төгрөгийн зээлийн хувийн хэрэгт шалгалт хийж, зээлийн зориулалт, ашиглалт болон холбогдох баримт бичгийн бүрдлийг хянан ажилласан байна.

Үүнээс 93 зээлдэгчийн 3,765.6 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан, 3 зээлдэгчийн 190.0 төгрөгийн зээлийг малын саравч, хашаа хороо барьж, засварласан эсэхийг биечлэн хяналт хийж баталгаажуулах шийдвэр гаргаж, 1 зээлдэгчийн 50.0 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй тул Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь заалтыг үндэслэн Улсын байцаагчийн 2025/12050/003 дугаар мэдэгдлээр үүрэг өгч зээлийг төлүүлсэн байна.

Зээлийн батлан даалтын сангийн Хангайн бүсийн салбарын хяналт:

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн Хангайн бүсийн салбар 2024-2025 онд Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймгийн нийт 4,359 хоршооны гишүүн малчны 131.9 тэрбум төгрөгийн зээлд 101.0 тэрбум төгрөгийн батлан даалт гаргуулах хүсэлтийг шийдвэрлэж ажилласан байна. Үүнээс Өвөрхангай аймагт 224 хоршооны 639 гишүүн малчны 23.1 тэрбум төгрөгийн зээлд 14.9 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зээлийн батлан даалтын сангийн Хангайн бүсийн салбарын “Хоршооны гишүүн малчны зээл”-д хийсэн хяналт мониторингийн нэгдсэн тайланд Өвөрхангай аймагт 2024-2026 онд зээлдэгчидтэй давхардсан тоогоор 1,756 удаа холбогдож, 639 зээлдэгчийн 4.8

¹⁵ 8.1.Банкны дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн ашиглалт, зарцуулалтад хагас жил хяналт тавьж, дотоод аудитын тайланг хагас жил тутам Монголбанканд хүргүүлнэ.

тэрбум төгрөгийн зээлийн төлөлтийг төвлөрүүлсэн талаар дурдсан байна. Дээрх онуудад хяналт хийсэн сумд, зээлдэгчийн тоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 17. Зээлийн батлан даалтын сангаас хяналт хийсэн мэдээлэл

№	Хяналтаар ажилласан	2024	2025	2026
1	Сумдын тоо	11	17	16
2	Хоршооны тоо	61	194	114
3	Зээлдэгчийн тоо	270	1306	355
4	Зайны хяналтын тоо	225	1214	317
5	Газар дээр биечилсэн хяналтын тоо	45	92	38

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сангийн Хангайн бүсийн салбарын "Хоршооны гишүүн малчны зээл"-д хийсэн хяналт мониторингийн нэгдсэн тайлан

Дээрхээс харвал зээлийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллахдаа "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8.3¹⁶-т заасан зээлийн ашиглалт, зарцуулалтад тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй, 7.8.1¹⁷-д заасан үүргийг биелүүлэн, зээлийн эргэн төлөлтөд түлхүү анхааран хяналт тавьж ажилласан байна.

Цаашид "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээгээр хүлээсэн хяналтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, зээлийн зориулалтын ашиглалт, зарцуулалтад тавих хяналт-шинжилгээг эрсдэлд суурилсан аргачлалаар тогтмол зохион байгуулан, илэрсэн зөрчилд шуурхай арга хэмжээ авч, хэрэгжилтийн үр дүнд тогтмол үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Иймд "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудад зөвлөмж хүргүүлж ажиллав.

2.2.4. Аудитын түүвэрт хамрагдсан хөнгөлөлттэй зээлд хамрагдсан малчдын ихэнх нь зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнд хүрсэн боловч, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд "Хоршооны гишүүн малчны зээл"-д 414 хоршооны 1486 зээлдэгч 51,253.3 сая төгрөгийн зээл авч хамрагдсан байна.

Дүрслэл 8. Аймгийн хэмжээнд зээл авсан зээлдэгч болон зээлийн дүн /банкаар/



Хөнгөлөлттэй зээл хамрагдсан нийт зээлдэгчдийн зээлийн зориулалтыг зарцуулалтаар нь авч үзэхэд нийт олгосон зээлийн 36,552.4 сая төгрөг буюу 71.3 хувийг үржлийн мал худалдан авах, бойжуулах, борлуулах зориулалтаар олгосон байна. Харин мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, тэжээлийн үйлдвэрлэл, агуулах, хөргүүр, усан хангамж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл зэрэг нэмүү өртөг шингээх, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн санхүүжилт нийт зээлийн 28.7 хувийг эзэлж байна.

¹⁶ 8.3."Хоршооны гишүүн малчны зээл"-ийн ашиглалт, зарцуулалтад хяналт шалгалт тавина. Хяналт тавихтай холбоотойгоор төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос туслалцаа дэмжлэг авч болно.

¹⁷ 7.8.1.Зээлийн батлан даалтын сангаас үүрэг гүйцэтгэсэн зээлийг төлүүлэх арга хэмжээг банктай хамтран авах;

Хүснэгт 18. "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн зарцуулалт, /зориулалтаар, /сая төгрөгөөр/

№	Зээлийн зориулалтын төрөл	Тоо	Дүн
1	Бэлчээрт худаг уст цэг гаргах усан хангамж байгуулах	77	2,367.2
2	Мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх	2	100.0
3	Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлэх	36	1,074.0
4	ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих өргөтгөх засварлах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл автомашин тоног төхөөрөмж худалдан авах	106	3,265.7
5	Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах тэжээлийн үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	83	3,185.3
6	Мал бордох аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	92	1,704.3
7	Мах сүү цагаан идээ бэлтгэх боловсруулах үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	61	1,780.3
8	Үржлийн мал худалдан бойжуулах борлуулах	1089	36,552.4
9	Ноос ноолуур арьс шир бэлтгэх анхан шатны тордолт хийх цэг цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	4	160.0
10	Мал малын гаралтай түүхий эдийн агуулах зоорь хөргүүр байгуулах	29	1,047.8
11	Бусад	2	16.3
Нийт дүн			51,253.3

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

МУЕА-ын 2018 оны А/151 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах" зааврын дагуу аудитын баг "Хоршооны гишүүн малчны зээл"-д хамрагдсан нийт 1486 зээлдэгчээс түүврийн хүрээг алдааны хязгаар 5 хувиар, баталгааны түвшинг 95 хувиар тооцож, 305-аас доошгүй зээлдэгчийг түүвэрт хамруулбал, эх олонлогийг хангалттай хэмжээнд төлөөлж чадна гэж авч үзсэн.

Зээлдэгчийн тоо харьцангуй өндөр сумдыг эрсдэлийн түвшин өндөртэй гэж үнэлэн, Өлзийт, Баян-Өндөр, Сант, Төгрөг, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Уянга, Арвайхээр сумдын 110 хоршооны 329 зээлдэгчид олгосон 11,611.7 сая төгрөгийн зээлийг түүвэрт хамруулан шалгалт хийсэн.

Аудитын биет шалгалтын үеэр үржлийн мал худалдан авах, бойжуулах, борлуулах зориулалтаар олгосон зээлийн хөрөнгийн ашиглалтыг шалгаж, зээлийн зориулалтын хэрэгжилтийг бодитой үнэлэхэд хүндрэл учруулсан дараах нөхцөл байдал илэрсэн. Тодруулбал:

- Малын А дансны мэдээллийг тулган баталгаажуулахад малын тооллогын комиссын мэдээлэл бүртгэх үйл ажиллагаа болон малчны мэдээлэл өгөх хариуцлага хангалтгүй байснаас шалтгаалан малын тоо толгойн мэдээлэлд зөрүү үүссэн, малын шилжилт хөдөлгөөн бүрэн бүртгэгдээгүй.

Жишээ нь: Мал тооллогын комисс нь малчдын газарзүйн байршил, малчдын эзгүй байснаас шалтгаалан утсаар болон аман байдлаар зөвхөн одоо байгаа малын тоог авдаг, малчид худалдаж авсан болон зах зээлд худалдаж, борлуулсан малын тоогоо малын А дансанд бичүүлдэггүй зэрэг зөрчил байна.

- Зээлдэгч нь зуд, цаг агаарын хүндрэл зэрэг байгалийн эрсдэлийн улмаас малын хорогдол, тэжээлийн хомсдолоос сэргийлэх зорилгоор зээлийн хөрөнгөөр худалдан авсан малыг борлуулсан байна.
- Зээлийн хөрөнгөөр худалдан авсан үржлийн малын тодорхой хэсэг нь ээмэг, цахим чипгүй, эсхүл ялган таних боломжгүй байсан нь тухайн малыг зээлийн хөрөнгөөр худалдан авсан эсэхийг бодитой тогтоох, зээлийн зориулалтын ашиглалтад үнэлгээ хийхэд хүндрэлтэй байсан.
- Зээлийн хөрөнгөөр худалдан авсан үржлийн малын худалдан авалтыг нотлох гэрээ, төлбөрийн баримт болон бусад холбогдох материалыг бүрэн бүрдүүлээгүй байсан.

•

**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Үржлийн мал худалдан авах, бойжуулах, борлуулах зориулалтаар зээл авсан нийт 1036 зээлдэгчдийн 2023-2025 оны мал тооллогын мэдээллийг аймгийн Статистикийн хэлтсээс авч, тулгалт хийхэд 411 зээлдэгчийн 13,519.7 сая төгрөгийн зээл малын А дансны мэдээлэлд худалдан авсан шилжилт хөдөлгөөн бүртгэгдээгүй ба зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нотлох боломжгүй байна.

Иймд малын А дансны бүртгэл, мал тооллогын мэдээлэл болон бусад нотлох баримтад үндэслэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулах зөвлөмжийг Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбарт хүргүүлээ.

Малын тооллого, бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, малын тооллогын комисс болон малчдын мэдээлэл үнэн зөв гаргаж өгөх хариуцлагыг нэмэгдүүлэх, малын А дансны мэдээллийн үнэн зөв байдлыг тогтмол баталгаажуулах, төрийн мэдээллийн сангийн бодит, найдвартай байдлыг хангах, мэдээллийн зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага үүссэн байна.

Засгийн газраас хүүгийн хөнгөлөлт үзүүлж, Зээлийн батлан даалтын сангийн батлан даалттай, бага хүүтэй олгосон “Хоршооны гишүүн малчны зээл” нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн, өндөр ач холбогдолтой, бодит үр дүнтэй арга хэмжээ болсон хэдий ч аудитын түүвэрт хамрагдсан зээлдэгчдэд илэрсэн зөрчил нь нийт зээлийн хэрэгжилтэд ижил төрлийн эрсдэл, зөрчил байх магадлалыг харуулж байна.

Иймд түүвэрт хамрагдаагүй зээлдэгчдийн зээлд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлж, шаардлагатай арга хэмжээг авах нь зүйтэй ба цаашид зээлийн ашиглалтад тавих хяналтыг тогтмолжуулах замаар зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн хөнгөлөлттэй зээлийг хоршоонд бус, хоршооны гишүүн малчинд олгосон нь хоршооны хамтын бизнес, дундын хөрөнгө, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөгжүүлэхээс илүүтэйгээр хувь малчны хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэгдсэн тул хөтөлбөрийн хүрээнд хоршооны чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсгэсэн байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тайлан баталгаажуулах тушаал:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/20

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалт, 2025 оны А/161 дүгээр тушаалаар баталсан "Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Монгол банк, Хаан банк, Төрийн банк, Хас банкны Өвөрхангай аймаг дахь салбаруудад хүргүүлж ажиллахыг Ахлах аудитор (Б.Баяртогтох)-д үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллан, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан), Монгол банкны Өвөрхангай аймаг дахь салбарын захирал (Ч.Чулуунцэцэг), Хаан банкны Өвөрхангай аймаг дахь салбарын захирал (Д.Энхбат), Төрийн банкны Өвөрхангай аймаг дахь салбарын захирал (Ш.Баярцэцэг), Хас банкны Өвөрхангай аймаг дахь салбарын захирал (Ш.Жамбал-ендон) нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын менежер (П.Хорлоосүрэн), Ахлах аудитор (Б.Баяртогтох) нарт даалгасугай.
5. "Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон зөвлөмжийг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор статистик мэдээний бүртгэлийн маягтын дагуу бүртгэн баталгаажуулж, 5 хоногийн дотор Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор (Б.Баяртогтох), Аудитор, эрх зүйч (Б.Нямсэмжаан)-д тус тус үүрэг болгосугай.

9225010050

D:\Auditin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 30 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг Аудитор (Г.Нинжбалгар)-г үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Холбогдох байгууллагын санал:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
МОНГОЛБАНКНЫ САЛБАР

Д.Пүрэвдоржийн гудамж 1-105, 13 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62166,
Утас/Факс: (976) 7032 2337,
Цахим шуудан: mb_57@mongolbank.mn,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2026-06-29 № А/18
танай 2026-06-26-ны № 433 -т

Тоотын хариу хүргүүлэх тухай

Аудитын тайлангийн төсөлд манай салбарын үйл ажиллагааны талаар "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд олгогдсон зээлийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй гэж дүгнэсэнтэй холбогдуулан дараах тайлбарыг хүргүүлж байна.

Манай салбар нь Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан орон нутаг дахь банкны нэгжид хийх хяналт, шалгалтын удирдамж болон салбарын жилийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу банкны нэгжүүдэд иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг тогтмол зохион байгуулж ажилладаг.

Иж бүрэн шалгалтыг дараах үндсэн 5 чиглэлээр хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Активын чанар;
2. Удирдлагын чадвар;
3. Нягтлан бодох бүртгэл;
4. Татан төвлөрүүлсэн хөрөнгө, харилцагчийн үйлчилгээ;
5. Ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурь, эрсдэлийн удирдлага

"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн өрийн үлдэгдэл нь аймгийн банкны салбарын нийт зээлийн 2.2 хувийг эзэлж байна. Шалгалт хийхдээ аймгийн банкны салбарт үлдэгдэлтэй 20 төрлийн, 68,0 мянга орчим зээлдэгчийн зээлээс эрсдэлд суурилсан түүврийн аргаар сонгон шалгалт хийдэг бөгөөд бүх зээлдэгчийг нэг бүрчлэн шалгах боломжгүй юм.

Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан "Шинэ хоршоо – Чинээлэг малчин", "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8.2 дахь заалтын дагуу хоршооны зээлийн хугацаа хэтрэлтийн байдалд банкны нэгжүүдээс ирүүлдэг ФИНА тайланд үндэслэн сар бүр зайнаас хяналт тавьж ажилласан. Уг хяналтаар чанаргүй ангилалд шилжсэн, эрсдэл үүсгэсэн зээл илрээгүй болно. Түүнчлэн "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд олгогдсон зээлийн ашиглалт, зарцуулалтад түүврийн аргаар 97 зээлдэгч дээр газар дээрх шалгалт хийж, 1 зээлдэгчийн зээл зориулалт бусаар ашигласан тул буцаан дуудсан. Харин нийт 1,487 хоршооны зээлдэгчийг нэг бүрчлэн газар дээр нь шалгах нь хүний нөөц, цаг хугацааны боломжийн хувьд бодитой хэрэгжих боломжгүй нөхцөл юм.

Иймд манай салбар нь холбогдох хууль тогтоомж, Монголбанкны баталсан удирдамж, жилийн хяналт шалгалтын төлөвлөгөө болон санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан чиг үүргийн хүрээнд боломжит хяналтыг хэрэгжүүлэн ажилласан гэж үзэж байна.



ЗАХИРАЛ

Ч.НУЛУУНЦЭЦЭГ



2026-A4.doc

Саналд өгсөн тайлбар:

Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбарын 2026 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/18 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг хүлээж аваагүй, нотлох баримтаар тулган баталгаажуулсан болно.

д/д	Ирүүлсэн санал	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар
1	Аудитын тайлангийн төсөлд манай салбарын үйл ажиллагааны талаар “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд олгогдсон зээлийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй гэж дүгнэсэнтэй холбогдуулан дараах тайлбарыг хүргүүлж байна. Манай салбар нь Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан орон нутаг дахь банкны нэгжид хийх хяналт шалгалтын удирдамж болон салбарын жилийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу банкны нэгжүүдэд иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг тогтмол зохион байгуулж ажилладаг. Иж бүрэн шалгалтыг дараах үндсэн 5 чиглэлээр хэрэгжүүлдэг. Үүнд: 1. Активын чанар; 2. Удирдлагын чадвар; 3. Нягтлан бодох бүртгэл; 4. Татан төвлөрүүлсэн хөрөнгө, харилцагчийн үйлчилгээ; 5. Ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурь, эрсдэлийн удирдлага “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн өрийн үлдэгдэл нь аймгийн банкны салбарын нийт зээлийн 2,2 хувийг эзэлж байна. Шалгалт хийхдээ аймгийн банкны салбарт үлдэгдэлтэй 20 төрлийн, 68,0 мянган зээлдэгчийн зээлээс эрсдэлд суурилсан түүврийн аргаар сонгон шалгалт хийдэг бөгөөд бүх зээлдэгчийг нэг бүрчлэн шалгах боломжгүй юм. Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо – Чинээлэг малчин”, “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8.2 дахь заалтын дагуу хоршооны зээлийн хугацаа хэтрэлтийн байдалд банкны нэгжүүдээс ирүүлдэг ФИНА тайланд үндэслэн сар бүр зайнаас хяналт тавьж ажилласан. Уг хяналтаар чанаргүй ангилалд шилжсэн, эрсдэл үүсгэсэн зээл илрээгүй болно. Түүнчлэн “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд олгогдсон зээлийн ашиглалт, зарцуулалтад түүврийн аргаар 97 зээлдэгч дээр газар дээрх шалгалт хийж, 1 зээлдэгчийн зээл зориулалт бусаар ашигласан тул буцаан дуудсан. Харин нийт 1,487 хоршооны зээлдэгчийг нэг бүрчлэн газар дээр нь шалгах нь хүний нөөц, цаг хугацааны боломжийн хувьд бодитой хэрэгжих боломжгүй нөхцөл юм. Иймд манай салбар нь холбогдох хууль тогтоомж, Монголбанкны баталсан удирдамж, жилийн хяналт шалгалтын төлөвлөгөө болон санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан чиг үүргийн хүрээнд боломжит хяналтыг хэрэгжүүлэн ажилласан гэж үзэж байна.	Тус тайлангийн 2.2.3-т “Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбар, Зээлийн батлан даалтын сан, арилжааны банк нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, зээлийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна” гэж дүгнэсэн нь “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн 2024 оны 240509/84, 240508/03-372, 1824/173 дугаар ерөнхий гэрээний 8.1, 8.2, 8.3-т заасан зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих чиг үүргийг холбогдох байгууллагууд бүрэн хэрэгжүүлээгүй болохыг аудитын явцад цуглуулж, тулган баталгаажуулсан хангалттай, зохистой нотлох баримтаар тогтоосон. Иймд уг саналыг хүлээн авах боломжгүй.



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2376, 7032 2325,
Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn
Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2026. 06. 29 № 2/334

танай _____-ны № _____-т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл,
эргэн төлөлт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлантай танилцсан болно.

ОРЛОГЧ



М.БАТЗОРИГ

6226 15 0324

D:My Doc. A5 albanbichig /ZD/



ХААН БАНК

XXL-9807001013
OBOPXAHHAJI CAJIAAP
Opaueaiaa auaa,
Apaiaaap aua, 13-p aa
Yaa: 976-70322040
www.khaibank.com

2026 оны 06 дугаар
сарын 29-ны өдөр

N₂ 5540/0401

Арвайхээр сум

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Шинэ хоршоо хөдөлгөөн төслийн хүрээнд ХААН Банкаас олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Манай банкнаас санал хүсэлт байхгүй болно.

ХААН БАНКНЫ ӨВӨРХАНГАЙ
САЛБАРЫН ЗАХИРАЛ

Д.ЭНХБАТ



ТӨРИЙН БАНК
ӨВӨРХАНГАЙ САЛБАР

62160, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум

13 дугаар баг, Б.Ренчинпэлжээгийн

1 дүгээр гудамж 105

Утас: 70323899, Факс: (976) 7032 3899

И-мэйл: s1900@statebank.mn

Вэбсайт: www.statebank.mn, Лавлах төв: 1800-1881

2026.06.29 № 36/221
Танай -ны № -т

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээлийн эргэн төлөлт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн тайлантай танилцсан.

Манай банкны зүгээс буцаан дуудах зээл байхгүй тул тайлантай холбоотой санал байхгүй болно.

САЛБАРЫН ЗАХИРАЛ



Ш.БАЯРЦЭЦЭГ



2026 оны 06 сарын 29 өдөр

№ 11/422

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан.

Манай банкны зүгээс тайлан төсөлтэй холбоотой санал хүсэлт байхгүй болно.

ЗАХИРАЛ



Ш.ЖАМБАЛ-ЁНДОН

ӨВӨРХАНГАЙ САЛБАР
Өвөрхангай аймаг, Арвайхээр сум,
8-р баг, Рашаант өлзийтийн тойруу
гудамж, 345 байр, 1-р давхар, ХасБанк

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Вед: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

1100695

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг өгч байна.

Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолыг 2024-2029 онд хэрэгжүүлэхээр баталсан ч суурь үзүүлэлт, хүрэх түвшнийг он тус бүрээр нарийвчилж бодитой тусгаагүй нь тухайн жилд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй, үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын оролцоо тодорхойгүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл бүрэн бус, үр дүнг нэгтгэн тайлагнаагүй нь хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.
- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эрчимжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд орон нутагт хоршоодыг чадавхжуулах сургалт зохион байгуулах, жишиг хоршоо хөгжүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа, зээл авсан хоршоодын төслийн үр дүнг үнэлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зээлд хамрагдсан хоршоодын санхүүгийн хяналт, ил тод байдлыг сайжруулах зэрэг ажлын хэрэгжилт хангалтгүй байна.
- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2024, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцах болон хамтран хэрэгжүүлэх байгууллагаар аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, ХХААГ-ыг тусгасан боловч орон нутагт хэрэгжүүлэх бодлого, оролцогч талуудын уялдаа хангалтгүй байна.
- “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ нь талуудын үндсэн эрх, үүргийг зохицуулсан боловч хэрэгжилтийн хяналт, байгууллагуудын уялдаа, мэдээлэл солилцоо, үр дүнгийн үнэлгээ болон хариуцлагын зохицуулалт хангалтгүй байна.
- Хоршоодын 51.4 хувь нь санхүүгийн тайлан гаргаж, нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй байгаа нь холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлээгүй, хоршоодын санхүүгийн чадавх сул, санхүү, татварын тайлан гаргах мэдлэг, ур чадвар дутмаг байгаа нь хоршооны үйл ажиллагааны тогтвортой байдал, хариуцлагатай тайлагналд сөргөөр нөлөөлж байна.
- Өвөрхангай аймгийн хэмжээнд Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын дагуу 2024, 2025 онуудад нийт 414 хоршооны 1486 малчинд 51,253.3 сая төгрөгийн зээлийг арилжааны банкнуудаар дамжуулан олгосноос 2026 оны 3 дугаар сарын 31-ны байдлаар 1470 зээлдэгчийн зээлийн эргэн төлөлт арилжааны банкнуудтай байгуулсан гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн төлөгдөж байна.
- Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн “Малчны тодорхойлолт” нь малчин болон мал бүхий иргэнийг ялган тодорхойлох боломжгүй байгаа нь зээл хүсэгчийн шалгуур шаардлагыг үнэн зөв тодорхойлоход эрсдэл үүсгэж, шаардлага хангаагүй этгээдэд хөнгөлөлттэй зээл олгогдох нөхцөлийг бүрдүүлсэн тул 111 мал бүхий иргэнд нийт 3,583.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.
- “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээгээр хүлээсэн хяналтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, зээлийн зориулалтын ашиглалт, зарцуулалтад тавих хяналт-шинжилгээг эрсдэлд суурилсан аргачлалаар тогтмол зохион байгуулан, илэрсэн зөрчилд шуурхай арга хэмжээ авч, хэрэгжилтийн үр дүнд тогтмол үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст:

- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд хөнгөлөлтэй зээлд хамрагдсан 213 хоршоонд хууль тогтоомжид заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах талаар мэргэжлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж, тайлангийн сахилга хариуцлагыг сайжруулж, санхүүгийн тайланг хүлээн авах арга хэмжээг зохион байгуулж ажиллах;

Монголбанкны Өвөрхангай аймаг дахь салбарт:

- Үржлийн мал худалдан авах зориулалттай зээлд малын А дансны бүртгэл, мал тооллогын мэдээлэл болон бусад нотлох баримтад үндэслэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулах;

Монголбанк, ХААН, ХАС, Төрийн банкны Өвөрхангай аймаг дахь салбаруудад:

- “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээгээр хүлээсэн хяналтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, аудитын түүвэрт хамрагдаагүй зээлүүдэд зээлийн зориулалтын ашиглалт, зарцуулалтад тавих эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг зохион байгуулан, илэрсэн зөрчилд холбогдох хууль, журам, гэрээний заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах;

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлэх санал

- E-Mongolia системийн “Малчны тодорхойлолт”-ын малчин, мал бүхий иргэнийг ялгах боломжгүй байгаа нь “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн гэрээ, журамд шаардлага хангаагүй зээлдэгчидтэй холбоотой эрх зүйн зохицуулалт тодорхойгүй, зээлийн шалгуур, хяналт, буцаан төлүүлэх зохицуулалтыг сайжруулах талаар шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

Хавсралт-1 Санхүүгийн тайлан ирүүлээгүй хоршоодын жагсаалт

№	Хоршооны нэр	Санхүүгийн тайлан гаргаж, бүртгэл хөтөлсөн эсэх /Тийм, Үгүй/	№	Хоршооны нэр	Санхүүгийн тайлан гаргаж, бүртгэл хөтөлсөн эсэх /Тийм, Үгүй/
1	Дөлгөөн бумбат	Үгүй	108	Угалз галуут хоршоо	Үгүй
2	ҮРЖИХ ИРЭЭДҮЙ ХОРШОО	Үгүй	109	ХАРУУЛ ТОЛГОЙ ХОРШОО	Үгүй
3	БАЯН ХООЛОЙН БУЯН ХОРШОО	Үгүй	110	НАРИЙН ЖАЛГЫН БУЯН ХОРШОО	Үгүй
4	ХАЯА БАЯН ГОВЬ ХОРШОО	Үгүй	111	Жинлав нүүрээд хоршоо	Үгүй
5	АР МАНДАЛЫН БУЛАГ ХОРШОО	Үгүй	112	ШАШИР МАНДАЛ ХАНГАЙ ХОРШОО	Үгүй
6	ӨСӨХ ХОС ЗУЛ ЗАЯА ХОРШОО	Үгүй	113	БАРУУН ТҮРҮҮ ҮР ШИМ ХОРШОО	Үгүй
7	ШУРАНГЫН БУЯН ӨЛЗИЙ ХОРШОО	Үгүй	114	Өлний арынхан хоршоо	Үгүй
8	Жамбал талбиу эрдэнэ хоршоо	Үгүй	115	МӨНХ БАЯН ДҮҮРЭН ХОРШОО	Үгүй
9	Дүгнэ хайрхан булаг хоршоо	Үгүй	116	НАВТГАРЫН НУУРЫН ТАЛ ХОРШОО	Үгүй
10	Дэвшин дэлгэрэх онгийн өгөөж хоршоо	Үгүй	117	ХӨСГӨНӨ БУЛАГ ХОРШОО	Үгүй
11	УРТ УХАА ХОРШОО	Үгүй	118	БАРУУН ХОНШООР ХОРШОО	Үгүй
12	ШИНЭ ЯЛАЛТ ШИНЭ ҮЕ ХОРШОО	Үгүй	119	ИХЭР БАЯЛАГ ХОРШОО	Үгүй
13	Өртөө гарам	Үгүй	120	ЭРДЭНИЙН ХИШИГ ДАЛАЙ ХОРШОО	Үгүй
14	Ам цагаан есөн хулгана хоршоо	Үгүй	121	БОЗОЙН ХОШУУНЫ УНДРАГА ХОРШОО	Үгүй
15	Хөх сэрэхүй ухаарахуй хоршоо	Үгүй	122	МААНЬТ САРЛАГИЙН ШИМ ХОРШОО	Үгүй
16	Тасархай баруун намаг хоршоо	Үгүй	123	МӨНХ ЧАНДАГАТАЙ СҮРЭГ ХОРШОО	Үгүй
17	ШУРАНГА ҮХРИЙН ОМОГ ХОРШОО	Үгүй	124	АРВАЙН ТАЛЫН ТУНАМАЛ ӨГӨӨЖ ХОРШОО	Үгүй
18	АСГАТ УНДРАХ БИЛЭГ	Үгүй	125	БОГЖНЫ ӨВРИЙН ЭНГЭР ХОРШОО	Үгүй
19	ҮРЖИН ДЭЛГЭРЭХ ӨВӨР ЭЛСТИЙ	Үгүй	126	ХОНГОРЫН ТАЛЫН ДӨРӨЛЖ ХОРШОО	Үгүй
20	Усан хавтгай жалбаа хоршоо	Үгүй	127	ЧИХ ТОЛГОЙН БУЯН ХОРШОО	Үгүй
21	САРНЫ ТОСГОН ХОРШОО	Үгүй	128	МОЙЛТЫН НҮДЭН НУУР ХОРШОО	Үгүй
22	ЗҮҮН УЛААН САРЛАГИЙН ХОРШОО	Үгүй	129	ШИНЭ УС, ЧУЛУУТ БУЛАГ ХОРШОО	Үгүй
23	Дөлгөөн мухар хоршоо	Үгүй	130	ДҮГИЙН ЭНГЭР ХОРШОО	Үгүй
24	ТОД ТӨГӨЛДӨР ХОРШОО	Үгүй	131	МОТОДЫН ЭНГЭРИЙН ӨВ ХОРШОО	Үгүй
25	АХАН ДҮҮСИЙН ҮЙЛСЭН АРВИН ХОРШОО	Үгүй	132	БАЯН ЦАЙДАМ ОРГИЛОХ	Үгүй
26	МАЙНТЫН ТҮМЭН СҮРЭГ ХОРШОО	Үгүй	133	СОНОРЫН ГОЗГОР ХОРШОО	Үгүй
27	ХҮРЭН ТОЛГОЙ ӨӨД ХОРШОО	Үгүй	134	ДЭЛГЭР ЦАЙДАМ СОЁОЛЖ	Үгүй
28	Онгоны буян хоршоо	Үгүй	135	ШАНДАН ШИРЭЭ ХОРШОО	Үгүй
29	Хязгааргүй шим хоршоо	Үгүй	136	ХАРУУЛ ЗУЗААН ХОРШОО	Үгүй
30	Гешон нутаг хоршоо	Үгүй	137	ЕРӨӨЛТИЙН НОГТ ХОРШОО	Үгүй
31	Залуурт баянхангайн чадвар хоршоо	Үгүй	138	ЗАДГАЙ ЖАРГАЛАНТЫН ТҮМЭН СҮРЭГ	Үгүй
32	ГАРЬДЫН ХАД ДЭВШИЛТ ХОРШОО	Үгүй	139	НАМАГ БУРХАНТ ХОРШОО	Үгүй
33	ЗЭГСТ ХОНГОР ХАЛЗАН	Үгүй	140	ШАНД САЙР БУЛАГ ХОРШОО	Үгүй
34	Угалз сам хоршоо	Үгүй	141	ШАНАГАН ХАВТГАЙ ХОРШОО	Үгүй
35	СҮҮТ ЦАГААН ДЭЛИЙН ӨВӨР	Үгүй	142	ДҮҮРЭН ДҮҮРЭН ИВЭЭЛ ХОРШОО	Үгүй
36	ХАРГАНЫ ХАР АМ ХОРШОО	Үгүй	143	АСАГТЫН АВАРГА ХОРШОО	Үгүй
37	БУЯНТ ГОЛЫН ЭНГЭРИЙН ӨТӨГ ХОРШОО	Үгүй	144	ХОНГОРЫН ЦОХИО ХОРШОО	Үгүй

38	БУМАН ХУРГА	Үгүй	145	ХӨГЖЛИЙН ХООЛОЙ	Үгүй
39	ДЭВЖИХ УУЛЗВАР ХОРШОО	Үгүй	146	МАЖГАРЫН ЦАГААН ОВОО	Үгүй
40	МӨНГӨН ЧУЛУУЛТЫН РАШААН	Үгүй	147	МААЖИГ ХЭЭР ХОРШОО	Үгүй
41	ЭРДЭНЭ САРУУЛ БАЯН ХАНГАЙ ХОРШОО	Үгүй	148	БАЯН ШАР ЧУЛУУ	Үгүй
42	Хангайн амт хоршоо	Үгүй	149	ТӨМӨРТ ХҮНХЭР ХОРШОО	Үгүй
43	Дайчин булаг хоршоо	Үгүй	150	ХӨӨВРИЙН БУЛАН ХОРШОО	Үгүй
44	ДАГНАЛТАЙ ЗУРАА ХОРШОО	Үгүй	151	ЗУЗААН ОВГИЙН ҮХЭР СҮРЭГ ХОРШОО	Үгүй
45	Өсөн дэвжих өртөнт	Үгүй	152	ГАХАЙТЫН ТАЛЫН БУУЦ ХОРШОО	Үгүй
46	Төгс оргих мааньт хоршоо	Үгүй	153	ЭЛСТ УХАА ЦАВ ХОРШОО	Үгүй
47	ТОВОГИЙН ШИРЭЭ ХОРШОО	Үгүй	154	ШАР ТОЛГОЙТЫН ӨНДӨР ХОРШОО	Үгүй
48	Баяжих бат тулга хоршоо	Үгүй	155	ДЭЛГЭРЭХ БУЛАГ ХОТГОР ДҮҮРЭН ХОРШОО	Үгүй
49	Ханбургатайн хишэг хоршоо	Үгүй	156	ХАМАР ДАВАА ХОРШОО	Үгүй
50	Хадатын бор овоо хоршоо	Үгүй	157	ШИНЭ ӨГЛӨӨНИЙ МАЛЧИН ХОРШОО	Үгүй
51	ТУЯАГИЙН ЗҮҮН ЭНГЭРИЙН ТҮМЭН СҮРГИЙН ХИШИГ ХОРШОО	Үгүй	158	ЦӨӨН МОД ХОРШОО	Үгүй
52	ЭЛСТ ЦОХИО ХОРШОО	Үгүй	159	ШУРАНГА ТАРВАГАТАЙ ХАЙРХАН ХОРШОО	Үгүй
53	ТОГИЛЫН ӨГӨӨЖ ХОРШОО	Үгүй	160	УЛААН НУУРЫН ДЭВСЭГ ХОРШОО	Үгүй
54	Баянхайрхан эрээн уул хоршоо	Үгүй	161	АЛТАН ТАЛ АЛТАН ОЧИР ХОРШОО	Үгүй
55	Өсөх дэвшилт дөлгөөн хоршоо	Үгүй	162	БУРГАСНЫ ӨНДӨР ХОРШОО	Үгүй
56	АЛДАРТ ХӨХӨЛТЭЙ ДААГА ХОРШОО	Үгүй	163	ХОНГОР БҮҮДЭН ХОРШОО	Үгүй
57	Цэцэгтсайхан тал ундрага	Үгүй	164	БУЛШТ ХАЙРХАН ХОРШОО	Үгүй
58	Онгийн цагаан бургас хоршоо	Үгүй	165	БУРГАСАН ТАСАРХАЙ ӨЛГИЙ НУТАГ ХОРШОО	Үгүй
59	ЦӨӨВӨРТ БАЯНХАЙРХАН ХОРШОО	Үгүй	166	СӨВТ ХАЙРХАН ХОРШОО	Үгүй
60	ХҮРДЭТ УХАА	Үгүй	167	АРЦ БОГДЫН ЗҮҮН ТЭРГҮҮН ХОРШОО	Үгүй
61	Ивээлт сүргийн буян хоршоо	Үгүй	168	ЗҮҮН БУЛАНГИЙН АЛТАН ТУГАЛ ХОРШОО	Үгүй
62	шар бүрдийн үзэмж хоршоо	Үгүй	169	БАЯН ШОВОГИЙН ТЭЭГ ХОРШОО	Үгүй
63	Тарвагат хүрэн хайрхан хоршоо	Үгүй	170	СУХАЙН ЦЭЦЭГ ХОРШОО	Үгүй
64	Дүүрэн дэвших оргил хоршоо	Үгүй	171	ОРГИЛ ГҮМҮДА ХОРШОО	Үгүй
65	Элстий төмөрт хоршоо	Үгүй	172	ГУРВАН ЭРЭЭЛЖҮҮТИЙН БУЯН ХОРШОО	Үгүй
66	Бумбан арал хоршоо	Үгүй	173	ДӨЛГӨӨН ЖАРГАЛАНТ ХИШИГ ХОРШОО	Үгүй
67	ӨСӨХ БАЯН АРВАЙ ХОРШОО	Үгүй	174	САЛХИТЫН ЧУЛУУН ХОРООТ ХОРШОО	Үгүй
68	ШАНДНЫ УЛААН ТОЛГОЙ ХОРШОО	Үгүй	175	ХУШГИН ИШИЙН БУЛАГ ХОРШОО	Үгүй
69	ЛОДОЙН ӨГӨӨЖ ХОРШОО	Үгүй	176	ЦАГААН ИРМЭГИЙН ТАЛ ХОРШОО	Үгүй
70	БАЯНЗҮРХ БАЯНХАНГАЙ ХОРШОО	Үгүй	177	АЛДАР ХАЙРХАН ӨГӨӨЖ ХОРШОО	Үгүй
71	ХӨХ ТАРИАН ТҮРҮҮ ХОРШОО	Үгүй	178	МАЙНТЫН ТАЛЫН УРГАЦ ХОРШОО	Үгүй
72	ОНГИ ТАРВАГАТ ХОРШОО	Үгүй	179	БАГА БИЛҮҮТИЙН ТАЛ ХОРШОО	Үгүй
73	Дулаан зээргэнт хоршоо	Үгүй	180	Цэцэгтийн түмэн сүрэг хоршоо	Үгүй
74	Бор даагат	Үгүй	181	ХЭЛТГИЙН ЭНГЭР ХОРШОО	Үгүй
75	Буурал асагт үхрийн хоршоо	Үгүй	182	БУМБАТ ХОНХОР ДӨЛГӨӨН ХАЙРХАН ХОРШОО	Үгүй
76	Хөх энгэр дөлгөөн хоршоо	Үгүй	183	ӨВӨР САЙР ХАЙРХАН ХОРШОО	Үгүй
77	Луусын хааны савдаг хоршоо	Үгүй	184	ДАЯЧИЙН ЦАГААН ТЭЭГ ХОРШОО	Үгүй
78	Бунханта хайрханы ивээл хоршоо	Үгүй	185	ИХ ХӨӨВРИЙН БУЛАГ ХОРШОО	Үгүй
79	Хамтын хүч хөдөлмөр хоршоо	Үгүй	186	БОЗОЙН ТАВАН ЭРДЭНЭ ХОРШОО	Үгүй

80	Их элстэй хүрээ хоршоо	Үгүй	187	МӨНГӨТИЙН ДЭВСЭГ ХОРШОО	Үгүй
81	Аз хийморийн хэвлий хоршоо	Үгүй	188	БААРАЙН ДАВАА ШОНТ ХОРШОО	Үгүй
82	ЦЭЦЭНГИЙН САЙХАН ДЭНЖ	Үгүй	189	АГШ БЭРХ ХОРШОО	Үгүй
83	ГЭРЭЛТ НАМУУН ДАЛАЙ	Үгүй	190	УЛААН НУУРЫН БАРУУН ДӨРӨЛЖ	Үгүй
84	ШУРАНГА ДООД БӨӨРӨГ ХОРШОО	Үгүй	191	АМАН УС ЗҮҮН АЦ ХОРШОО	Үгүй
85	БИЧИГТ ХҮРЭЭ ХОРШОО	Үгүй	192	ХОНХОРЫН ГОЛЫН УСАН ХӨЛ ХОРШОО	Үгүй
86	ХУЙТАН РАШААН ХОРШОО	Үгүй	193	ТААЦ ЗАМТЫН БАРУУН САЛАА ХОРШОО	Үгүй
87	УЛААН НУУРЫН БУЯН	Үгүй	194	БАЯН ХОНГИЛТ ХОРШОО	Үгүй
88	БАЯЛАГ МОД ТҮМЭН СҮРЭГ ХОРШОО	Үгүй	195	БАЯН ХАЙРХАНЫ ТҮШИГ ХОРШОО	Үгүй
89	Дэвжих сүргийн тансаг буян хоршоо	Үгүй	196	АРВИН СЭРТЭН ХОРШОО	Үгүй
90	Ундай хүрэн хоршоо	Үгүй	197	ХИШИГ АРВИЖИХ ЧИМЭЭ ХОРШОО	Үгүй
91	УЯНГА ЭВСЭЛ ХОРШОО	Үгүй	198	БАЯНТОЛГОЙН СҮРЭГ ХОРШОО	Үгүй
92	МӨНХ ГЭРЛИЙН ХҮЧ	Үгүй	199	ЛУУСТ ХОРШОО	Үгүй
93	Зүүн хоолойн сүрэг хоршоо	Үгүй	200	МӨНХ ЗАДГАЙТ ХАЙРХАН ХОРШОО	Үгүй
94	Хишигт наран хайрхан хоршоо	Үгүй	201	ӨВГӨДИЙН ӨЛГИЙ ХОРШОО	Үгүй
95	Адаг булаг хоршоо	Үгүй	202	ТАВАН ОВООНЫ ХИШИГ ХОРШОО	Үгүй
96	Хунхын өгөөж хоршоо	Үгүй	203	ТАРАВЖИЙН ТАЛ ХОРШОО	Үгүй
97	БУЯНТ САЙЖРАХ ХОРШОО	Үгүй	204	ЛААНС ХАЙРХАН ХОРШОО	Үгүй
98	ДЭВШИЛ САЙРЫН УС ХОРШОО	Үгүй	205	ИХ АРВИЖИХ АРЦАД	Үгүй
99	ЦАЙДАМЫН ШАР ХУДАГ ХОРШОО	Үгүй	206	ТЭВХИЙН БОР ХОШУУ ХОРШОО	Үгүй
100	Шандаст сүрэг хоршоо	Үгүй	207	АР ХАДАТЫН ХИЙМОРЬ ХОРШОО	Үгүй
101	Хангайн хөх хошуу хоршоо	Үгүй	208	УРГАХ САРАН ДЭЛГЭРЭХ	Үгүй
102	УУЛЫН ХӨХ ХУРУУ ХОРШОО	Үгүй	209	Олз дүүрэн сайхан хоршоо	Үгүй
103	Цэцэн хөвийн ундарга хоршоо	Үгүй	210	Их морин булаг	Үгүй
104	Дөлгөөн уул хөндлөн булаг	Үгүй	211	Шандын булаг мараа хоршоо	Үгүй
105	Уужим сайхан далай хоршоо	Үгүй	212	БУМБАТ БАЯН ТЭРЭМ ХОРШОО	Үгүй
106	ЭРДЭНИЙН ХИШИГ ТУЛГА ХОРШОО	Үгүй	213	АГУЙТ АРВИЖИХ	Үгүй
107	ДЭВСЭГИЙН ХУДАГ ХОРШОО	Үгүй			

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn